



СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 06 сарын 16 өдөр

Дугаар 1/27

Улаанбаатар хот

Ажил мэргэжлийн жагсаалт, албан тушаалын тодорхойлолтод нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.3.1, 103.3.2 дахь заалт, Соёлын өвийн үндэсний төвийн Хөдөлмөрийн дотоод журмын 3.1.1 дэх заалт, Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус Үндэсний төвийн ажил мэргэжлийн жагсаалт, албан тушаалын тодорхойлолтод дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай.

- Албан тушаалын тодорхойлолтын “Дагаж мөрдөх огноо” хүснэгт дэх “2021.07.02” гэснийг залруулж, энэхүү тушаал батлагдсан огноог бичих;

-Үйлчилгээ, аж ахуйн албаны нэршлийг Үйлчилгээ, аюулгүй байдлын алба болгон өөрчлөх;

-Захиргааны мэргэжилтэн албан тушаалыг ажил мэргэжлийн жагсаалт, албан тушаалын тодорхойлолтод нэмэх;

-Ажил мэргэжлийн жагсаалт, албан тушаалын тодорхойлолтод монгол бичгээр унших, хэрэглээний программд бичих мэдлэг, ур чадварыг; Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангахтай холбогдуулан байгууллагын албан ёсны psch.gov.mn цахим хуудсанд оруулах газар нэгжийнхээ үйл ажиллагааны нээлттэй мэдээллийг ажилтан, албан хаагчид бэлтгэж өгөх, Олон нийттэй харилцах ажилтан бэлтгэсэн мэдээллүүдийг нэгтгэх, Программист нэгтгэсэн мэдээллийг цахим хуудсанд байршуулах, газар нэгжийн дарга нар уг ажлыг удирдан зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг; Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтний ажлын гүйцэтгэлд байгууллагын албан ёсны цахим хуудасны англи хэл дээрх мэдээллийг хариуцан бэлтгэх, орчуулах, хянах чиг үүргийг тус тус нэмж тусгах;

-Ерөнхий нягтлан бодогч, Тооцооны нягтлан бодогч албан тушаалын ажил мэргэжлийн жагсаалт, албан тушаалын тодорхойлолтод албан тушаалын зорилго, зорилтын агуулга, тус бүрийн гүйцэтгэх чиг үүргийг шинэчлэн боловсруулсныг тусгах;


-Шинжээчийн ажлын байрны ажил мэргэжлийн жагсаалт, албан тушаалын тодорхойлолтод албан тушаалын зорилго, зорилтын агуулга, өв тус бүрийн гүйцэтгэх чиг үүрэг, хариуцлага, оролцоо, албан тушаалд тавигдах тусгай шаардлагад мэргэжлийн хүрээ, мэргэшлийн тодорхойлолтыг шинэчлэн боловсруулсныг тусгах;

2.Дээрх нэмэлт өөрчлөлтийг оруулан “Ажил мэргэжлийн жагсаалт”-ыг 1 дүгээр, “Албан тушаалын тодорхойлолт”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

1723010379

3. Ажил мэргэжлийн жагсаалт, албан тушаалын тодорхойлолтод орсон нэмэлт өөрчлөлтийг хэрэгжүүлэн ажиллахыг Үндэсний төвийн бүх ажилтнуудад, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэ тушаал баталсантай холбогдуулан Үндэсний төвийн захирлын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/27 дугаар “Ажил мэргэжлийн жагсаалт, албан тушаалын тодорхойлолт батлах тухай” тушаалыг хүчингүйд тооцугай.

ЗАХИРАЛ  Г.ЭНХБАТ

УЛААНБААТАР
9104208 ХН 1839
11181552

АГУУЛГА

Ажил мэргэжлийн жагсаалт

I. ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗАР

- Захиргаа, удирдлагын газрын дарга
- Үйлчилгээ, аж ахуйн албаны дарга
- Ерөнхий нягтлан бодогч
- Тооцооны нягтлан бодогч
- Нярав
- Захиргааны мэргэжилтэн
- Дотоод хяналт, шалгалт хариуцсан ажилтан
- Хүний нөөцийн ажилтан
- Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
- Олон нийттэй харилцах ажилтан
- Архив, бичиг хэргийн эрхлэгч
- Цахилгаанчин
- Слесарь
- Жолооч
- Үйлчлэгч
- Үйлчлэгч (гадна талбайн)

II. БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ГАЗАР

- Бүртгэл, мэдээллийн газрын дарга
- Ерөнхий бүртгэл, мэдээллийн санч
- Бүртгэл, мэдээллийн санч (Түүх, соёлын үл хөдлөх дурсгал хариуцсан)
- Бүртгэл, мэдээллийн санч (Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл хариуцсан)
- Бүртгэл, мэдээллийн санч (Баримтат өв хариуцсан)
- Бүртгэл, мэдээллийн санч (Соёлын биет бус өв хариуцсан)
- Бүртгэл, мэдээллийн санч (Архивч)

III. ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ, ТЕХНОЛОГИ СУДАЛГААНЫ ГАЗАР

- Хадгалалт хамгаалалт, технологи судалгааны газрын дарга
- Ерөнхий технологич
- Сэргээн засварлагч (Хадгалалт хамгаалалтын технологи хариуцсан)
- Сэргээн засварлагч (Археологийн олдвор хариуцсан)
- Ариутгалын технологич (Химич)

IV. СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ ГАЗАР

- Сэргээн засварлах газрын дарга
- Ерөнхий сэргээн засварлагч
- Сэргээн засварлагч (даавуу, зөөлөн эдлэл)
- Сэргээн засварлагч (уран зураг, монгол зураг)
- Сэргээн засварлагч (металл эдлэл)
- Сэргээн засварлагч (мод, ясан эдлэл)
- Сэргээн засварлагч (чулуун эдлэл)
- Сэргээн засварлагч (уран баримал, керамик)
- Сэргээн засварлагч (арьс, ширэн эдлэл)
- Сэргээн засварлагч (археологийн олдвор)

Сан хөмрөгч

V. ТҮҮХЭН ДУРСГАЛТ БАРИЛГА, АРХИТЕКТУРЫН ДУРСГАЛЫГ ХАМГААЛАХ ГАЗАР

Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг хамгаалах газрын дарга
Инженер

Архитектурын зураг төслийн мэргэжилтэн

VI. АВРАН ХАМГААЛАХ, ЭРСДЭЛИЙН СУДАЛГААНЫ ГАЗАР

Авран хамгаалах, эрсдэлийн судалгааны газрын дарга

Шинжээч (Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын)

Шинжээч (Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн)

Шинжээч (Соёлын биет бус өвийн)

VII. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР

Мэдээллийн технологийн газрын дарга

Программист

Компьютер графикч


Инженер (Газар зүйн мэдээллийн зайнаас тандан судлах)

Оператор

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---------|--|
| БМС | Бүртгэл, мэдээллийн сан |
| СББӨ | Соёлын биет бус өв |
| СӨУНБМС | Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан |
| СӨҮТ | Соёлын өвийн үндэсний төв |
| СТОУС | Санхүү тайлагналын олон улсын стандарт |
| ТСДЗ | Түүх, соёлын дурсгалт зүйл |
| ТСҮХД | Түүх, соёлын үл хөдлөх дурсгал |
| ТСХДЗ | Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл |
| ҮАМАТ | Монгол Улсын Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт |

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2023 оны 06 дугаар сарын 16-ны
өдрийн 0127 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт



I. ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗАР

Захиргаа, удирдлагын газрын дарга

I.1. Ажлын байрны товч тодорхойлолт

Байгууллагын санхүү, захиргаа, хүний нөөц, бодлого, төлөвлөлт, судалгаа, олон нийтийн харилцаа, маркетинг болон нэгжийн ерөнхий үйл ажиллагааг төлөвлөх, бусад газар нэгжүүдийг удирдан чиглүүлэх, хянан зохицуулах.

| | |
|--|--|
| Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт (YAMAT-08) дахь мэргэжлийн индекс код | 1213-12 |
| Олон улсын ажил мэргэжлийн ангилал (ISCO-08) | 1213 |
| Боловсруулсан огноо | 2022 оны 5 дугаар сарын 25 |
| Баталсан байгууллага | Соёлын өвийн үндэсний төв |
| Хянан засварлах хугацаа | YAMAT эсвэл хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон |

I.2. Ажлын байрны тухай мэдээлэл

I.2.1. Ажил мэргэжлийн ерөнхий ба тусгай бэлтгэл

Удирдахуйн ухаан, хууль эрх зүй, менежмент, түүх, соёл, соёлын өвийн чиглэл мэргэжилтэй магистр болон түүнээс дээш зэрэгтэй.

I.2.2. Гүйцэтгэх үүрэг:

- Байгууллагын зорилго, зорилт, стратеги төлөвлөгөө, бодлого, хөтөлбөр, үйл явц, тогтолцоо, журмыг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах;
- Захиргаа, менежментийн чиглэлээр газрын дарга нарт стратегийн төлөвлөлт, үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх, зохион байгуулах, судалгаа, зөвлөгөөгөөр хангах;
- Байгууллагын үйл ажиллагааны тайлан, дүн мэдээг боловсруулах, судалгаанд суурилсан ирээдүйн хэтийн чиг төлөв байдлыг тодорхойлох;
- Хөдөлмөрийн дотоод журам, байгууллагад мөрдөх дэг журам, зааврыг боловсруулж, хэрэгжүүлэх;
- Байгууллагын нөөцийн менежментийн цогц асуудалд дүн шинжилгээ хийх, холбогдох тайлан, баримт бичгийг бэлтгэх;
- Ажилтны үйл ажиллагаагаа хэвийн явуулах болон үнэн бодитой, цаг үеийн мэдээллээр хангахад нь манлайлах, удирдах;
- Хэлэлцээ, хурал, цуглаан олон нийтийн арга хэмжээнд байгууллагаа төлөөлөх;
- Төсөв батлах, удирдах, хянах, нөөцийн үр ашигтай зарцуулалтыг хангах;
- Боловсон хүчний сонголт, гүйцэтгэлд хяналт тавих.

I.2.3. Хөдөлмөрлөх орчны эрүүл ахуйн нөхцөл, зохион байгуулалт, ажлын дэглэм

- Ажлын байр нь хэвийн нөхцөлтэй, дулаан байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй байна.

- Ажлын байр нь эрүүл ахуйн болон хөдөлмөрийн аюулгүй байдлын зохих шаардлагыг хангасан байна.
- Хөдөлмөрийн хууль тогтоомж, байгууллагын болон нэгжийн дотоод журмыг мөрдөж ажиллана.

1.2.4 Ажлын байранд ашиглах багаж хэрэгсэл

Соёлын өвийн үндэсний төвийн бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хүний нөөц, захиргаа удирдлагын баримт бүхий компьютер, хэвлэгч, ажлын стандарт бичгийн ширээ, сандал, баримт бичгийн шүүгээ зэрэг.

1.2.5. Мэдлэг

- Соёлын талаар төрөөс баримтлах бодлого, Хөдөлмөрийн тухай, Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Соёлын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Музейн тухай болон бусад холбогдох хууль, тогтоомж;
- Соёл, соёлын өвийн талаарх төрийн үйл ажиллагаа, бодлогын хэрэгжилт, хандлага, дүн шинжилгээ хийх;
- Гадаад хэлний мэдлэгтэй байх.

1.2.6. Мэргэжлийн ур чадвар

Хамт олныг удирдан зохион байгуулах, манлайлах, үйлчилгээ бизнесийн талаар мэргэшсэн, төлөвлөх, зохион байгуулах, дүн шинжилгээ хийх, илтгэх, тайлагнах.

1.2.7. Хандлага

- Ажил үүргээ гүйцэтгэх хүсэл тэмүүлэлтэй,
- Харилцааны өндөр соёлтой,
- Ёс зүйн дүрмийг баримталдаг байх,
- Бусадтай зөв боловсон харьцах,
- Хувийн зохион байгуулалт болон цагийн менежмент сайтай,
- Ой тогтоолт, анхаарал төвлөрөлт сайтай,
- Суралцах, мэргэжил дээшлүүлэх хүсэл сонирхолтой,
- Хамт олны дунд биеэ зөв авч явдаг байх,
- Бусдын шийдвэрийг хүндэтгэдэг,
- Бүтээлч сэтгэлгээтэй байх.

1.3. Хүлээх хариуцлага

| | |
|------------------------------|--|
| Хэний өмнө хариуцлага хүлээх | <ul style="list-style-type: none"> - Соёлын өвийн үндэсний төвийн захирал |
| Удирдан ажиллах ажилтан | <ul style="list-style-type: none"> - Газар нэгжийн дарга нар - Үйлчилгээ, аюулгүй байдлын албаны дарга - Ерөнхий нягтлан бодогч - Тооцооны нягтлан бодогч - Нярав - Захиргааны мэргэжилтэн - Дотоод хяналт, шалгалтын ажилтан - Хүний нөөцийн ажилтан - Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн - Олон нийттэй харилцах ажилтан - Архив, бичиг хэргийн эрхлэгч - Цахилгаанчин - Слесарь - Жолооч - Үйлчлэгч |

1.4. Мэргэжил дээшлүүлэх болон ирээдүйд ахиж дэвших боломж

| Холбогдох албан тушаалтан | Хөгжих дэвших боломж | | | Тусгай тэмдэглэл |
|-----------------------------------|----------------------|------|-------|-------------------|
| | Бага | Дунд | Өндөр | |
| Мэргэжил дээшлүүлэх боломж | | | + | |
| Удирдах албан тушаал | | | + | |
| Гүйцэтгэх албан тушаал | | | | Тэмдэглэл байхгүй |
| Өөр төрлийн ажил гүйцэтгэх боломж | | | + | |

---o0o---

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2023 оны 06 дугаар сарын 16-ны
өдрийн 117 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт



I. ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗАР

Үйлчилгээ, аюулгүй байдлын албаны дарга

I.1. Ажлын байрны товч тодорхойлолт

Байгууллагын аюулгүй байдлыг хангах, үйлчилгээний үйл ажиллагааг төлөвлөх, зохицуулах, зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих зэрэг удирдах үйл ажиллагааг гүйцэтгэх.

| | |
|--|--|
| Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт (YAMAT-08) дахь мэргэжлийн индекс код | 1219-12 |
| Олон улсын ажил мэргэжлийн ангилал (ISCO-08) | 1219 |
| Боловсруулсан огноо | 2023 оны 6 дугаар сарын 12 |
| Баталсан байгууллага | Соёлын өвийн үндэсний төв |
| Хянан засварлах хугацаа | YAMAT эсвэл хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон |

I.2. Ажлын байрны тухай мэдээлэл

I.2.1. Ажил мэргэжлийн ерөнхий ба тусгай бэлтгэл

Менежер, нягтлан бодох, эдийн засгийн болон нийгэм соёл, хүмүүнлэгийн чиглэлийн мэргэжилтэй, диплом, бакалавр, түүнээс дээш зэрэгтэй.

I.2.2. Гүйцэтгэх үүрэг:

- Байгууллагын үйлчилгээний чанар, хэмжээ, өртөг зардал, цаг хугацаа, ажиллах хүчин зэргийг нарийвчлан төлөвлөх, хариуцлагыг тодорхойлох;
- Байгууллагын материаллаг нөөцийг хөгжүүлэх, удирдах;
- Захиргаа, үйлчилгээний менежментийн асуудлаар бусад нэгжийн дарга нарыг зөвлөгөө, мэдээллээр хангах;
- Үндэсний төвийн барилгын цахилгаан, дулаан, цэвэр, бохир усны хэрэглээ, ашиглалтыг хариуцан зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих, холбогдох байгууллага, ажилтнуудтай хамтран ажиллах;
- Байгууллагын өрөө тасалгаа, заал танхимын хэвийн үйл ажиллагааг хангах, хангуулахад зохион байгуулан ажиллах;
- Байгууллага дээр зохион байгуулагдаж буй аливаа сургалт, хурал, зөвлөгөөн цуглаан зэрэг арга хэмжээний цэвэрлэгээ, үйлчилгээг хариуцах, зохион байгуулах;
- Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, машин техникийн ашиглалт, хэрэглээнд хяналт тавих, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал, стандарт, шаардлагын хэрэгжилтийг хангуулах;

- Байгууллагын дохиолол хамгааллын системийг шинэчлэх, байршуулах ажлыг зохион байгуулах, дохиолол хамгааллын системийн хэвийн үйл ажиллагаанд хяналт тавих, хэвийн ажиллагааны талаар шаардлагатай тохиолдолд Мэдээллийн технологийн газрын хариуцсан ажилтанд мэдэгдэх, засуулах зэрэг ажлыг зохион байгуулан ажиллах;
- Үйлчилгээ, аюулгүй байдлын талаар удирдлагыг мэдээллээр хангах, үйл ажиллагаатай холбогдох тайлан, бичиг баримтуудыг цуглуулж эмхэтгэх, тайлагнах, архивлан хадгалах;

1.2.3. Хөдөлмөрлөх орчны эрүүл ахуйн нөхцөл, зохион байгуулалт, ажлын дэглэм

- Ажлын байр нь хэвийн нөхцөлтэй, дулаан байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй байна.
- Ажлын байр нь эрүүл ахуйн болон хөдөлмөрийн аюулгүй байдлын зохих шаардлагыг хангасан байна.
- Хөдөлмөрийн хууль тогтоомж, байгууллагын болон нэгжийн дотоод журмыг мөрдөж ажиллана.

1.2.4. Ажлын байранд ашиглах багаж хэрэгсэл

Байгууллагын аюулгүй байдлыг хангах, үйлчилгээний үйл ажиллагаатай холбогдох баримт бүхий компьютер, хэвлэгч, баримтаа эмхэлж цэгцлэхэд шаардлагатай хэрэгсэл, ажлын стандарт бичгийн ширээ, сандал, баримт бичгийн шүүгээ зэрэг.

1.2.5. Мэдлэг

- Хөдөлмөрийн хууль, Төрийн албаны тухай, Соёлын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж;
- Бичгийн соёл, хэл бичгийн дүрэм, найруулга;
- Сүүлийн үеийн дэвшилтэт программ хангамж, техник технологи, мэдээллийн орчинд ажиллах.

1.2.6. Мэргэжлийн ур чадвар

Бичгийн соёл, монгол хэлний хэл зүйн дүрэм, найруулгын өндөр ур чадвартай байх, баримт бичгийг заавар журмын дагуу хөтөлж хадгалах зэргийг журмын дагуу нягт нямбай алдаагүй гүйцэтгэдэг, хурал зөвлөгөөн, албан уулзалтыг зохицуулан төлөвлөх, утсаар соёлтой харилцах, и-мэйл, факсаар мэдээлэл хүлээн авах, илгээх үйлчлэх соёл, дэг жаягийг баримталдаг, өөрийн ажлын эцсийн үр дүндээ хариуцлага хүлээх чадвартай байх.

1.2.7. Хандлага

- Ажил үүргээ гүйцэтгэх хүсэл тэмүүлэлтэй,
- Харилцааны өндөр соёлтой,
- Ёс зүйн дүрмийг баримталдаг байх,
- Бусадтай зөв боловсон харьцах,
- Хувийн зохион байгуулалт болон цагийн менежмент сайтай,
- Нягт нямбай, үнэнч шударга,
- Ой тогтоолт, анхаарал төвлөрөлт сайтай,
- Суралцах, мэргэжил дээшлүүлэх хүсэл сонирхолтой,
- Хамт олны дунд биеэ зөв авч явдаг байх,
- Бусдын шийдвэрийг хүндэтгэдэг,
- Бүтээлч сэтгэлгээтэй байх.

1.3. Хүлээх хариуцлага

| | |
|------------------------------|---|
| Хэний өмнө хариуцлага хүлээх | <ul style="list-style-type: none"> - Соёлын өвийн үндэсний төвийн захирал - Захиргаа, удирдлагын газрын дарга |
|------------------------------|---|


| | |
|-------------------------|--|
| Удирдан ажиллах ажилтан | <ul style="list-style-type: none">- Нярав- Цахилгаанчин- Слесарь- Жолооч- Үйлчлэгч |
|-------------------------|--|

I.4. Мэргэжил дээшлүүлэх болон ирээдүйд ахиж дэвших боломж

| Холбогдох албан тушаалтан | Хөгжих дэвших боломж | | | Тусгай тэмдэглэл |
|-----------------------------------|----------------------|------|-------|------------------|
| | Бага | Дунд | Өндөр | |
| Мэргэжил дээшлүүлэх боломж | | | + | |
| Удирдах албан тушаал | + | | | |
| Гүйцэтгэх албан тушаал | | + | | |
| Өөр төрлийн ажил гүйцэтгэх боломж | | + | | |

---o0o---

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2023 оны 06 дугаар сарын 16-ны
өдрийн 077 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт



I. ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗАР

Ерөнхий нягтлан бодогч

I.1. Ажлын байрны товч тодорхойлолт

Үйл ажиллагааны төсвийн бүрдүүлэлт, зарцуулалт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг зохих журмын дагуу хөтлөх, мэдээллийн бүрдүүлэлтийг хянах, үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийн төлөвлөгөөг зардлын зүйл, нэр төрлөөр төлөвлөн батлуулах, сар, улирал, жилийн тайлан мэдээ гаргах, байгууллагын удирдлагыг санхүүгийн шийдвэр гаргахад үнэн зөв мэдээллээр хангах.

| | |
|--|--|
| Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт (YAMAT-08) дахь мэргэжлийн индекс код | 1211-12 |
| Олон улсын ажил мэргэжлийн ангилал (ISCO-08) | 1211 |
| Боловсруулсан огноо | 2022 оны 5 дугаар сарын 25 |
| Баталсан байгууллага | Соёлын өвийн үндэсний төв |
| Хянан засварлах хугацаа | YAMAT эсвэл хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон |

I.2. Ажлын байрны тухай мэдээлэл

I.2.1. Ажил мэргэжлийн ерөнхий ба тусгай бэлтгэл

Санхүү, нягтлан бодогч мэргэжлийн чиглэлээр бакалавр, түүнээс дээш зэрэгтэй.

I.2.2. Гүйцэтгэх үүрэг:

- Байгууллагын үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн орлого, зарлагын бүрдүүлэлт, гүйлгээнүүдийг хөтлөх;
- Байгууллагад ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгө болон машин эд хогшлын бүртгэл хөтлөх;
- Байгууллагын санхүүгийн байдлын тайлан балансыг СТОУС-ын дагуу, татварын тайланг Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу хөтлөх, бүрдүүлэх, хянах;
- Байгууллагын хөрөнгө түүний эх үүсвэр мөнгөн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийг хөтлөж, тайлан тэнцэл, мэдээ, судалгааг гаргах;
- Байгууллагын үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн орлого, зарлагын анхан шатны бүрдүүлэлтийг хийх, орлого, зарлагын гүйлгээ хийх, банкны хуулгыг авч үлдэгдлийг шалган цэгцэлж компьютерт оруулах, санхүүгийн тайлан, судалгаа гаргах, баримт үдэж, цэгцлэх;
- Байгууллагад ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгө болон машин эд хогшил бусад хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, тооллого хийж, үр дүнг тооцох, захиргааны зардал, туслах үйл ажиллагааны тооцоог бодож олгох, хянах;

- Байгууллагын санхүүгийн тайлан балансыг хугацаанд нь гаргах, анхан шатны бүртгэлийг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл гаргах, санхүү, нягтлан бодох, бүртгэлтэй холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах, нийгмийн даатгалын тооцоог хийж, эрүүл мэнд, нийгмийн даатгалын дэвтэрт бичилт хийж баталгаажуулах;
- Байгууллагын хөрөнгө түүний эх үүсвэр болон ажиллагааны үр дүнг тооцох, мөнгөн хөрөнгийн хөдлөл, жижиг мөнгөн сангийн бүртгэлийг хөтлөх, мөнгөн хөрөнгийн тайлан тэнцэл, мэдээ, судалгааг гаргах;
- Байгууллагын ажилчдын цалинг зохих журмын дагуу бодож олгох, холбогдох байгууллагуудтай тогтмол болон хувьсах зардлын тооцоог хийх;
- Нягтлан бодох бүртгэлийг холбогдох хууль, олон улсын стандартад нийцүүлэн бүртгэх, санхүүгийн тайланг гаргаж байгууллагын удирдлагад тайлагнах;
- Татвар, нийгмийн даатгал болон холбогдох аудит, санхүүгийн байгууллагад мэдээ, тайлан гаргаж өгөх, хянуулах.

1.2.3. Хөдөлмөрлөх орчны эрүүл ахуйн нөхцөл, зохион байгуулалт, ажлын дэглэм

- Ажлын байр нь хэвийн нөхцөлтэй, дулаан байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй байна.
- Ажлын байр нь эрүүл ахуйн болон хөдөлмөрийн аюулгүй байдлын зохих шаардлагыг хангасан байна.
- Хөдөлмөрийн хууль тогтоомж, байгууллагын болон нэгжийн дотоод журмыг мөрдөж ажиллана.

1.2.4. Ажлын байранд ашиглах багаж хэрэгсэл

Санхүүгийн программ, маягтууд баримт бүхий компьютер, хэвлэгч, тооны машин, баримтаа эмхэлж цэгцлэхэд шаардлагатай хэрэгсэл, ажлын стандарт бичгийн ширээ, сандал, баримт бичгийн шүүгээ зэрэг.

1.2.5. Мэдлэг

- Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай болон холбогдох бусад хуулиуд, Төрийн албаны тухай, Соёлын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Музейн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж;
- Сүүлийн үеийн дэвшилтэт программ хангамж, техник технологи, мэдээллийн орчинд ажиллах;
- Бусад байгууллага, нийгмийн даатгал, халамж, аудитын газар тооцоо хийх, мэдээлэл боловсруулах.

1.2.6. Мэргэжлийн ур чадвар

Санхүү, үйлчилгээ бизнесийн талаар мэргэшсэн, төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах, дүн шинжилгээ хийх, илтгэх, тайлагнах.

1.2.7. Хандлага

- Ажил үүргээ гүйцэтгэх хүсэл тэмүүлэлтэй,
- Харилцааны өндөр соёлтой,
- Ёс зүйн дүрмийг баримталдаг байх,
- Бусадтай зөв боловсон харьцах,
- Хувийн зохион байгуулалт болон цагийн менежмент сайтай,
- Ой тогтоолт, анхаарал төвлөрөлт сайтай, хурц хараа, ажигч гярхай
- Суралцах, мэргэжил дээшлүүлэх хүсэл сонирхолтой,
- Хамт олны дунд биеэ зөв авч явдаг байх,
- Бусдын шийдвэрийг хүндэтгэдэг,
- Бүтээлч сэтгэлгээтэй байх.

1.3. Хүлээх хариуцлага


| | |
|------------------------------|---|
| Хэний өмнө хариуцлага хүлээх | - Соёлын өвийн үндэсний төвийн захирал - Захиргаа, удирдлагын газрын дарга |
| Удирдан ажиллах ажилтан | - Тооцооны нягтлан бодогч - Нярав |

I.4. Мэргэжил дээшлүүлэх болон ирээдүйд ахиж дэвших боломж

| Холбогдох албан тушаалтан | Хөгжих дэвших боломж | | | Тусгай тэмдэглэл |
|-----------------------------------|----------------------|------|-------|-------------------|
| | Бага | Дунд | Өндөр | |
| Мэргэжил дээшлүүлэх боломж | | | + | |
| Удирдах албан тушаал | | | + | |
| Гүйцэтгэх албан тушаал | | | | Тэмдэглэл байхгүй |
| Өөр төрлийн ажил гүйцэтгэх боломж | | | + | |

---o0o---

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2023 оны 06 дугаар сарын 16-ны
өдрийн 178 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт



I. ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗАР

Тооцооны нягтлан бодогч

I.1. Ажлын байрны товч тодорхойлолт

Төсвийн бүрдүүлэлт, зарцуулалт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг зохих журмын дагуу хөтлөх, ангилах зэрэг ажлыг гүйцэтгэх, анхан шатны данс бүртгэлийг хөтлөхөд санхүүгийн баримтыг шалгах, нягтлах, илгээх, тогтмол хийгддэг тооцооллыг хийх, сар, улирал, жилийн тайлан мэдээ гаргах, удирдлагыг санхүүгийн шийдвэр гаргахад үнэн зөв мэдээллээр хангах.

| | |
|--|--|
| Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт (YAMAT-08) дахь мэргэжлийн индекс код | 4311-43 |
| Олон улсын ажил мэргэжлийн ангилал (ISCO-08) | 4311 |
| Боловсруулсан огноо | 2022 оны 5 дугаар сарын 25 |
| Баталсан байгууллага | Соёлын өвийн үндэсний төв |
| Хянан засварлах хугацаа | YAMAT эсвэл хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон |

I.2. Ажлын байрны тухай мэдээлэл

I.2.1. Ажил мэргэжлийн ерөнхий ба тусгай бэлтгэл

Санхүү, нягтлан бодогч мэргэжлийн чиглэлээр диплом, бакалавр, түүнээс дээш зэрэгтэй.

I.2.2. Гүйцэтгэх үүрэг:

- Байгууллагын үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн орлого, зарлагын бүрдүүлэлт, гүйлгээнүүдийг хөтлөх;
- Байгууллагад ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгө болон машин эд хогшлын бүртгэл хөтлөх;
- Үнэн зөв бүртгэл хөтлөхийн тулд тоо, баримтыг нягтлан шалгах, данс, бүртгэлийн дугаарыг нь шалгах,
- Нягтлан бодох, данс бүртгэлийн программ хангамжийг ашиглан, мэдээллийг оруулах, хадгалах, шинжилгээ хийх,
- Санхүүгийн тоон үзүүлэлтүүдийг ангилах, бүртгэх, нэгтгэх, санхүүгийн бүртгэлийг хэвлэх, товхимол болгон хадгалах,
- Нэхэмжлэл, төлбөр, дансны хуулга зэргийг тооцоолох, бэлтгэх,
- Статистик, санхүү, бүртгэлийн эсвэл аудитын дүгнэлтийн, түүнчлэн төлбөрийн баримт, зарлага, өрийн данс, авлагын данс, ашиг алдагдал зэрэг үзүүлэлтүүдийг тусгасан хавтаст материал бэлтгэх,
- Байгууллагын Шилэн дансны санхүүгийн холбогдолтой талбарын хөтлөлтийг хариуцан гүйцэтгэнэ.

I.2.3. Хөдөлмөрлөх орчны эрүүл ахуйн нөхцөл, зохион байгуулалт, ажлын дэглэм

- Ажлын байр нь хэвийн нөхцөлтэй, дулаан байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй байна.

- Ажлын байр нь эрүүл ахуйн болон хөдөлмөрийн аюулгүй байдлын зохих шаардлагыг хангасан байна.
- Хөдөлмөрийн хууль тогтоомж, байгууллагын болон нэгжийн дотоод журмыг мөрдөж ажиллана.

1.2.4. Ажлын байранд ашиглах багаж хэрэгсэл

Санхүүгийн программ, маягтууд баримт бүхий компьютер, хэвлэгч, тооны машин, баримтаа эмхэлж цэгцлэхэд шаардлагатай хэрэгсэл, ажлын стандарт бичгийн ширээ, сандал, баримт бичгийн шүүгээ зэрэг.

1.2.5. Мэдлэг

- Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай болон бусад холбогдох хуулиуд Төрийн албаны тухай, Соёлын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Музейн тухай болон бусад холбогдох хууль, тогтоомж;
- Сүүлийн үеийн дэвшилтэт программ хангамж, техник технологи, мэдээллийн орчинд ажиллах;
- Бусад байгууллага, нийгмийн даатгал, халамж, аудитын газар тооцоо хийх, мэдээлэл боловсруулах.

1.2.6. Мэргэжлийн ур чадвар

Санхүү, үйлчилгээ бизнесийн талаар мэргэшсэн, төлөвлөх, зохион байгуулах, дүн шинжилгээ хийх, илтгэх, тайлагнах.

1.2.7. Хандлага

- Ажил үүргээ гүйцэтгэх хүсэл тэмүүлэлтэй,
- Харилцааны өндөр соёлтой,
- Ёс зүйн дүрмийг баримталдаг байх,
- Бусадтай зөв боловсон харьцах,
- Хувийн зохион байгуулалт болон цагийн менежмент сайтай,
- Ой тогтоолт, анхаарал төвлөрөлт сайтай, хурц хараа, ажигч гярхай
- Суралцах, мэргэжил дээшлүүлэх хүсэл сонирхолтой,
- Хамт олны дунд биеэ зөв авч явдаг байх,
- Бусдын шийдвэрийг хүндэтгэдэг,
- Бүтээлч сэтгэлгээтэй байх.


1.3. Хүлээх хариуцлага

| | |
|------------------------------|---|
| Хэний өмнө хариуцлага хүлээх | - Соёлын өвийн үндэсний төвийн захирал - Захиргаа, удирдлагын газрын дарга - Ерөнхий нягтлан бодогч |
| Удирдан ажиллах ажилтан | - Нярав |

1.4. Мэргэжил дээшлүүлэх болон ирээдүйд ахиж дэвших боломж

| Холбогдох албан тушаалтан | Хөгжих дэвших боломж | | | Тусгай тэмдэглэл |
|-----------------------------------|----------------------|------|-------|-------------------|
| | Бага | Дунд | Өндөр | |
| Мэргэжил дээшлүүлэх боломж | | | + | |
| Удирдах албан тушаал | | | + | |
| Гүйцэтгэх албан тушаал | | | | Тэмдэглэл байхгүй |
| Өөр төрлийн ажил гүйцэтгэх боломж | | | + | |

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2023 оны 06 дугаар сарын 16-ны
өдрийн 027 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт



I. ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗАР

Нярав

I.1. Ажлын байрны товч тодорхойлолт

Байгууллагын санхүүгийн бүх гүйлгээтэй холбоотой анхан шатны нягтлан бодох бүртгэлийн бичилтийг хийж санхүү, аж ахуйн үйл ажиллагаатай холбогдох данс бүртгэл, бичиг баримтыг үнэн зөв, нягт нямбай хөтлөх.

| | |
|--|--|
| Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт (YAMAT-08) дахь мэргэжлийн индекс код | 4321-43 |
| Олон улсын ажил мэргэжлийн ангилал (ISCO-08) | 4321 |
| Боловсруулсан огноо | 2022 оны 5 дугаар сарын 25 |
| Баталсан байгууллага | Соёлын өвийн үндэсний төв |
| Хянан засварлах хугацаа | YAMAT эсвэл хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон |

I.2. Ажлын байрны тухай мэдээлэл

I.2.1. Ажил мэргэжлийн ерөнхий ба тусгай бэлтгэл

Санхүү, нягтлан бодогч, нярав чиглэлээр диплом, түүнээс дээш зэрэгтэй.

I.2.2. Гүйцэтгэх үүрэг:

- Нягтлан бодогчийн заавар, данс хөтлөлтийн ерөнхий зарчмыг дагаж санхүүгийн гүйлгээний анхан шатны баримт материалыг хөтлөх;
- Төлбөр, тооцоо, санхүүгийн бусад гүйлгээтэй холбоотой анхан шатны баримтуудын бүрдлийг хангах;
- Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой тооцооллыг хийхэд зориулагдсан компьютерын стандарт программ хангамжийг ашиглах;
- Бараа хүлээн авах ажлыг зохион байгуулах, хянах, холбогдох бүртгэлийг хөтлөх;
- Нөөцийн бүртгэл хөтлөх, хяналт тавих, эрэлт хэрэгцээг тодорхойлж захиалга хийх;
- Багаж хэрэгсэл, сэлбэг буюу төрөл бүрийн төхөөрөмж хүлээн авах, хадгалах ба олгох, бүртгэлийг нь хөтлөх;
- Байгууллагын өмч хөрөнгө, техник тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил болон бусад зүйлийг бүртгэн данс хөтлөх;
- Ажил, үйлчилгээнд шаардлагатай материалын тоо хэмжээ, чанар, нэр төрлийг нь тооцоолж гаргах;
- Материалын хэрэгцээг төлөвлөх, шаардлагатай үед нь тэдгээрийг бэлэн байлгах ба зохих бүртгэлийг хөтлөх;
- Нөөцийг шалгах, хангалтын ажлыг зохицуулах ба саатлын шалтгааныг олох;
- Агуулах, бараа материалыг хадгалах журам, зааврыг баримтлах;
- Холбогдох бусад үүргийг гүйцэтгэх.

I.2.3. Хөдөлмөрлөх орчны эрүүл ахуйн нөхцөл, зохион байгуулалт, ажлын дэглэм

- Ажлын байр нь хэвийн нөхцөлтэй, дулаан байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй байна.
- Ажлын байр нь эрүүл ахуйн болон хөдөлмөрийн аюулгүй байдлын зохих шаардлагыг хангасан байна.
- Хөдөлмөрийн хууль тогтоомж, байгууллагын болон нэгжийн дотоод журмыг мөрдөж ажиллана.

1.2.4. Ажлын байранд ашиглах багаж хэрэгсэл

Санхүүгийн программ, маягтууд баримт бүхий компьютер, хэвлэгч, тооны машин, баримтаа эмхэлж цэгцлэхэд шаардлагатай хэрэгсэл, ажлын стандарт бичгийн ширээ, сандал, баримт бичгийн шүүгээ зэрэг.

1.2.5. Мэдлэг

- Хөдөлмөрийн тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай, Соёлын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хууль зэрэг;
- Сүүлийн үеийн дэвшилтэт программ хангамж, техник технологи, мэдээллийн орчинд ажиллах;
- Үр дүнд хяналт шинжилгээ хийх, тооцоо хийх, мэдээлэл боловсруулах.

1.2.6. Мэргэжлийн ур чадвар

Бичиж боловсруулах, зохион байгуулах, ажил гүйцэтгэх, тайлагнах.

1.2.7. Хандлага

- Ажил үүргээ гүйцэтгэх хүсэл тэмүүлэлтэй,
- Харилцааны өндөр соёлтой,
- Ёс зүйн дүрмийг баримталдаг байх,
- Бусадтай зөв боловсон харьцах,
- Хувийн зохион байгуулалт болон цагийн менежмент сайтай,
- Нягт нямбай, үнэнч шударга
- Ой тогтоолт, анхаарал төвлөрөлт сайтай,
- Суралцах, мэргэжил дээшлүүлэх хүсэл сонирхолтой,
- Хамт олноор дунд биеэ зөв авч явдаг байх,
- Бусдын шийдвэрийг хүндэтгэдэг,
- Бүтээлч сэтгэлгээтэй байх,
- Төрийн өмчийн эд хогшлыг арвилан хамгаалах.

1.3. Хүлээх хариуцлага

| | |
|------------------------------|--|
| Хэний өмнө хариуцлага хүлээх | <ul style="list-style-type: none"> - Соёлын өвийн үндэсний төвийн захирал - Захиргаа, удирдлагын газрын дарга - Үйлчилгээ, аж ахуйн албаны дарга - Ерөнхий нягтлан бодогч - Тооцооны нягтлан бодогч |
| Удирдан ажиллах ажилтан | |

1.4. Мэргэжил дээшлүүлэх болон ирээдүйд ахиж дэвших боломж

| Холбогдох албан тушаалтан | Хөгжих дэвших боломж | | | Тусгай тэмдэглэл |
|-----------------------------------|----------------------|------|-------|-------------------|
| | Бага | Дунд | Өндөр | |
| Мэргэжил дээшлүүлэх боломж | | | + | |
| Удирдах албан тушаал | + | | | |
| Гүйцэтгэх албан тушаал | | | | Тэмдэглэл байхгүй |
| Өөр төрлийн ажил гүйцэтгэх боломж | | + | | |

18

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2023 оны 06 дугаар сарын 16...-ны
өдрийн 1127 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт



I. ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗАР

Захиргааны мэргэжилтэн

I.1. Ажлын байрны товч тодорхойлолт

Байгууллагын өдөр тутмын найдвартай, хэвийн үйл ажиллагааг хангахад төлөвлөх, боловсруулах, зохион байгуулах, зохицуулах, байгууллагаас гаргаж буй захиргааны шинжтэй баримтуудыг боловсруулах, санал дүгнэлт гаргах, батлуулах, хүргүүлэх ажлыг зохион байгуулах, захиргааны асуудлаар газар нэгжүүдэд стратегийн төлөвлөлт, үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх, судалгаа, зөвлөгөөгөөр хангах.

| | |
|--|--|
| Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт (YAMAT-08) дахь мэргэжлийн индекс код | 1219-12 |
| Олон улсын ажил мэргэжлийн ангилал (ISCO-08) | 1219 |
| Боловсруулсан огноо | 2023 оны 6 дугаар сарын 12 |
| Баталсан байгууллага | Соёлын өвийн үндэсний төв |
| Хянан засварлах хугацаа | YAMAT эсвэл хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон |

I.2. Ажлын байрны тухай мэдээлэл

I.2.1. Ажил мэргэжлийн ерөнхий ба тусгай бэлтгэл

Хууль эрх зүй, бизнесийн удирдлага, түүх, археологи, нийгэм, соёл, монгол хэл, хүмүүнлэгийн мэргэжлийн чиглэлээр диплом, бакалавр, түүнээс дээш зэрэгтэй.

I.2.2. Гүйцэтгэх үүрэг:

- Байгууллагаас гаргаж буй захиргааны шинжтэй баримтуудыг боловсруулах, санал дүгнэлт гаргах, батлуулах, хүргүүлэх ажлыг зохион байгуулах;
- Тогтоол шийдвэр, үүрэг даалгавар, зөвлөмжийн хэрэгжилтийг холбогдох нэгж, ажилтнаар гаргуулж, нэгтгэн удирдлагад тайлагнах;
- Захиргааны ерөнхий асуудлаар удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, хэрэгжилтийг тайлагнах, үнэн зөв мэдээлэх, цаг үеийн шаардлагаар гарсан ажлуудыг тухай бүр гүйцэтгэх;
- Байгууллагаас иргэн, байгууллагатай байгуулж буй аливаа гэрээ, хэлцэл, хамтын ажиллагааны баримт бичгийн төслийг боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулах;
- Иргэн, байгууллагатай байгуулсан гэрээ, хэлцэл, хамтын ажиллагааны баримт бичгийн дугаар олгох, бүртгэл хөтлөх, эх хувийг хадгалах, байгууллагын архивт шилжүүлэх;
- Ажилтныг хөгжүүлэхэд чиглэсэн аливаа арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүний нөөцөд дэмжлэг үзүүлэх, хамтран зохион байгуулах;
- Захиргааны асуудлаар газар нэгжүүдэд бусад стратегийн төлөвлөлт, үйл ажиллагааны мэдээллээр хангах, дэмжлэг үзүүлэх, судалгаа, зөвлөгөөгөөр хангах;

- Төсөл хөтөлбөр боловсруулах, санхүүгийн тайлан, төсөв гаргахад мэдээллээр хангах, дэмжлэг үзүүлэх;
- Байгууллагын тухайн оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулах ажлыг голлон зохион байгуулж, батлагдсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний улирал, хагас болон бүтэн жилийн гүйцэтгэлийг газар нэгж, холбогдох ажилтнуудаас хүлээн авч нэгтгэх, дээд шатны байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулах;
- Газрын тухайн оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулж, батлагдсан төлөвлөгөөний улирал, хагас болон бүтэн жилийн тайланг нэгтгэх, удирдлагад тайлагнах ажлыг зохион байгуулах;
- Байгууллагын 7 хоног тутмын ажлын тайланг мэдээг нэгтгэж, удирдах дээд байгууллагад хүргүүлэх;
- Байгууллагаас соёлын өвийн чиглэлээр зохион байгуулж буй аливаа сургалт, хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэг зэрэг арга хэмжээний нэгдсэн тоон дүн мэдээг хагас болон бүтэн жилээр гаргах, нэгтгэх ажлыг хариуцах;
- Удирдах дээд шатны байгууллага, албан тушаалтан, мэргэжлийн байгууллагаас өгсөн үүрэг даалгавар, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар санал өгөх, үнэн зөв мэдээллээр хангах;
- Байгууллагын хэмжээнд мөрдөгдөх дүрэм, журмыг боловсруулах болон боловсронгуй болгох талаарх саналаа удирдлагад танилцуулах, шийдвэрлүүлэх;
- Газар нэгжүүдээс гаргаж буй баримт бичгийн боловсруулалтад дэмжлэг туслалцаа үзүүлэх;
- Удирдах дээд шатны байгууллага, албан тушаалтан, мэргэжлийн байгууллагаас өгсөн үүрэг даалгавар, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар санал өгөх, үнэн зөв мэдээллээр хангах.

1.2.3. Хөдөлмөрлөх орчны эрүүл ахуйн нөхцөл, зохион байгуулалт, ажлын дэглэм

- Ажлын байр нь хэвийн нөхцөлтэй, дулаан байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй байна.
- Ажлын байр нь эрүүл ахуйн болон хөдөлмөрийн аюулгүй байдлын зохих шаардлагыг хангасан байна.
- Хөдөлмөрийн хууль тогтоомж, байгууллагын болон нэгжийн дотоод журмыг мөрдөж ажиллана.

1.2.4. Ажлын байранд ашиглах багаж хэрэгсэл

Байгууллагын үйл ажиллагааны холбогдох баримт бүхий компьютер, хэвлэгч, баримтаа эмхэлж цэгцлэхэд шаардлагатай хэрэгсэл, ажлын стандарт бичгийн ширээ, сандал, баримт бичгийн шүүгээ зэрэг.

1.2.5. Мэдлэг

- Хөдөлмөрийн хууль, Захиргааны ерөнхий хууль, Төрийн албаны тухай, Соёлын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Музейн тухай болон бусад холбогдох хууль, тогтоомж;
- Монгол хэлний хэл зүн дүрмийн мэдлэг, найруулан бичих өндөр чадвар;
- Сүүлийн үеийн дэвшилтэт программ хангамж, техник технологи, мэдээллийн орчинд ажиллах чадвар.

1.2.6. Мэргэжлийн ур чадвар

Бичгийн соёл, хэл зүй найруулгын өндөр ур чадвартай байх, баримт бичгийг заавар журмын дагуу хөтөлж хадгалах зэргийг журмын дагуу нягт нямбай алдаагүй гүйцэтгэдэг, хурал зөвлөгөөн, албан уулзалтыг зохицуулан төлөвлөх, утсаар соёлтой харилцах, и-мэйл, факсаар мэдээлэл хүлээн авах, илгээх үйлчлэх соёл, дэг жаягийг баримталдаг, өөрийн ажлын эцсийн үр дүндээ хариуцлага хүлээх чадвартай байх.

1.2.7. Хандлага

- Ажил үүргээ гүйцэтгэх хүсэл тэмүүлэлтэй,
- Харилцааны өндөр соёлтой,
- Ёс зүйн дүрмийг баримталдаг байх,
- Бусадтай зөв боловсон харьцах,
- Хувийн зохион байгуулалт болон цагийн менежмент сайтай,
- Нягт нямбай, үнэнч шударга,
- Ой тогтоолт, анхаарал төвлөрөлт сайтай,
- Суралцах, мэргэжил дээшлүүлэх хүсэл сонирхолтой,
- Хамт олны дунд биеэ зөв авч явдаг байх,
- Бусдын шийдвэрийг хүндэтгэдэг,
- Бүтээлч сэтгэлгээтэй байх.

I.3. Хүлээх хариуцлага


| | |
|------------------------------|---|
| Хэний өмнө хариуцлага хүлээх | - Соёлын өвийн үндэсний төвийн захирал - Захиргаа, удирдлагын газрын дарга |
| Удирдан ажиллах ажилтан | |

I.4. Мэргэжил дээшлүүлэх болон ирээдүйд ахиж дэвших боломж

| Холбогдох албан тушаалтан | Хөгжих дэвших боломж | | | Тусгай тэмдэглэл |
|-----------------------------------|----------------------|------|-------|------------------|
| | Бага | Дунд | Өндөр | |
| Мэргэжил дээшлүүлэх боломж | | | + | |
| Удирдах албан тушаал | | | + | |
| Гүйцэтгэх албан тушаал | | | + | |
| Өөр төрлийн ажил гүйцэтгэх боломж | | + | | |

---o0o---

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2023 оны 06 дугаар сарын 16-ны
өдрийн 0727 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт



I. ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗАР

Дотоод хяналт, шалгалтын ажилтан

I.1. Ажлын байрны товч тодорхойлолт

Байгууллагын үйл ажиллагаа, ажил үйлчилгээний хэрэгжилт хуулиар хүлээсэн чиг үүрэг, хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавьж, газар нэгжийн ажлыг уялдуулах, байгууллагын хэмжээнд илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, ажил үйлчилгээг сайжруулахад чиглэгдэх.

| | |
|--|--|
| Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт (YAMAT-08) дахь мэргэжлийн индекс код | 3343-33 |
| Олон улсын ажил мэргэжлийн ангилал (ISCO-08) | 3343 |
| Боловсруулсан огноо | 2022 оны 5 дугаар сарын 25 |
| Баталсан байгууллага | Соёлын өвийн үндэсний төв |
| Хянан засварлах хугацаа | YAMAT эсвэл хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон |

I.2. Ажлын байрны тухай мэдээлэл

I.2.1. Ажил мэргэжлийн ерөнхий ба тусгай бэлтгэл

Хууль эрх зүй, санхүү аудит, нийгэм, соёлын мэргэжлийн чиглэлээр магистр, түүнээс дээш зэрэгтэй.

I.2.2. Гүйцэтгэх үүрэг:

- Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр зэрэг хууль тогтоомжид заасан байгууллагын хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтэд тавих хяналт шалгалт;
- Байгууллагын үйл ажиллагаа мөрдөгдөж буй хууль эрх зүйн акт баримтуудад нийцсэн эсэх, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам, нэгжийн дотоод ажлын журам зэрэг холбогдох дүрэм журмын биелэлтэд хяналт шалгалт хийх;
- Хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, эрүүл ахуй шаардлага, өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт;
- Үйл ажиллагааны талаар мэдээлэл бэлтгэх, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих, биелэлтийг хангуулах;
- Газар нэгжүүдийн ажлын гүйцэтгэлийн чанарт тавих хяналт шалгалтыг зохион байгуулах, тайлагнах, дүгнэх;
- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хагас болон бүтэн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг нэгтгэн боловсруулах;
- Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар ажилтнуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;
- Ажилтнуудын нийтээр дагаж мөрдөх, мэдвэл зохих хууль тогтоомж, хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг байгууллагад сурталчлах, хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулах;

- Илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг тодруулан зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авах, шаардлагатай бол илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг арилгах болон зөрчил гаргасан этгээдэд хариуцлага ногдуулах талаар байгууллагын удирдлагад санал тавьж шийдвэрлүүлэх;
- Холбогдох дүрэм, журам, байгууллагын стандартыг боловсронгуй болгох талаар судалгаа, дүгнэлт гаргах;
- Хийсэн хяналт шалгалтын талаар бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх;
- Дотоод хяналт, шалгалтын талаар удирдлагыг мэдээллээр хангах, үйл ажиллагаатай холбогдох тайлан, бичиг баримтуудыг цуглуулж эмхэтгэх, тайлагнах, архивлан хадгалах.

1.2.3. Хөдөлмөрлөх орчны эрүүл ахуйн нөхцөл, зохион байгуулалт, ажлын дэглэм

- Ажлын байр нь хэвийн нөхцөлтэй, дулаан байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй байна.
- Ажлын байр нь эрүүл ахуйн болон хөдөлмөрийн аюулгүй байдлын зохих шаардлагыг хангасан байна.
- Хөдөлмөрийн хууль тогтоомж, байгууллагын болон нэгжийн дотоод журмыг мөрдөж ажиллана.

1.2.4. Ажлын байранд ашиглах багаж хэрэгсэл

Дотоод хяналттай холбоотой баримт бичиг, компьютер, хэвлэгч, баримтаа эмхэлж цэгцлэхэд шаардлагатай хэрэгсэл, ажлын стандарт бичгийн ширээ, сандал, баримт бичгийн шүүгээ зэрэг.

1.2.5. Мэдлэг

- Хөдөлмөрийн тухай, Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Соёлын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Музейн тухай болон бусад холбогдох хууль, тогтоомж;
- Монгол хэлний хэл зүн дүрмийн мэдлэг, найруулан бичих өндөр чадвар;
- Сүүлийн үеийн дэвшилтэт программ хангамж, техник технологи, мэдээллийн орчинд ажиллах чадвар.

1.2.6. Мэргэжлийн ур чадвар

Ажлаа төлөвлөх, зохион байгуулах, нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх өндөр чадвартай, ёс зүйтэй, монгол хэл бичгийн дүрэм, найруулгын өндөр мэдлэг чадвар сайтай, нягт нямбай гүйцэтгэдэг, соёл, дэг жаягийг баримталдаг, өөрийн ажлын эцсийн үр дүндээ хариуцлага хүлээх чадвартай байх.

1.2.7. Хандлага

- Ажил үүргээ гүйцэтгэх хүсэл тэмүүлэлтэй,
- Харилцааны өндөр соёлтой,
- Ёс зүйн дүрмийг баримталдаг байх,
- Бусадтай зөв боловсон харьцах,
- Хувийн зохион байгуулалт болон цагийн менежмент сайтай,
- Нягт нямбай, үнэнч шударга,
- Ой тогтоолт, анхаарал төвлөрөлт сайтай,
- Суралцах, мэргэжил дээшлүүлэх хүсэл сонирхолтой,
- Хамт олны дунд биеэ зөв авч явдаг байх,
- Бусдын шийдвэрийг хүндэтгэдэг,
- Бүтээлч сэтгэлгээтэй байх.

I.3. Хүлээх хариуцлага

| | |
|------------------------------|---|
| Хэний өмнө хариуцлага хүлээх | - Соёлын өвийн үндэсний төвийн захирал - Захиргаа, удирдлагын газрын дарга |
| Удирдан ажиллах ажилтан | |


I.4. Мэргэжил дээшлүүлэх болон ирээдүйд ахиж дэвших боломж

| Холбогдох албан тушаалтан | Хөгжих дэвших боломж | | | Тусгай тэмдэглэл |
|-----------------------------------|----------------------|------|-------|------------------|
| | Бага | Дунд | Өндөр | |
| Мэргэжил дээшлүүлэх боломж | | | + | |
| Удирдах албан тушаал | | | + | |
| Гүйцэтгэх албан тушаал | | | + | |
| Өөр төрлийн ажил гүйцэтгэх боломж | | | + | |

---o0o---

24

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2023 оны 16 дугаар сарын 16-ны
өдрийн 0/07 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт



I. ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗАР

Хүний нөөцийн ажилтан

I.1. Ажлын байрны товч тодорхойлолт

Байгууллагын боловсон хүчний болон хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх бодлогыг хэрэгжүүлэх, зохион байгуулах, ажиллагсдын сэлгээ, албан тушаалын өөрчлөлт, үр дүнгийн үнэлгээ, албан хаагчийн амралт, чөлөө, цалин хөлс, мэргэжил, сургалтын тухай бүртгэл, мэдээллийг хадгалж шинэчилж байх үүргийг гүйцэтгэх.

| | |
|--|--|
| Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт (YAMAT-08) дахь мэргэжлийн индекс код | 4416-44 |
| Олон улсын ажил мэргэжлийн ангилал (ISCO-08) | 4416 |
| Боловсруулсан огноо | 2022 оны 5 дугаар сарын 25 |
| Баталсан байгууллага | Соёлын өвийн үндэсний төв |
| Хянан засварлах хугацаа | YAMAT эсвэл хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон |

I.2. Ажлын байрны тухай мэдээлэл

I.2.1. Ажил мэргэжлийн ерөнхий ба тусгай бэлтгэл

Хүний нөөц, хууль эрх зүйн мэргэжил болон холбогдох чиглэлээр магистр, түүнээс дээш зэрэгтэй.

I.2.2. Гүйцэтгэх үүрэг:

- Ажилтны хөдөлмөрлөх эрх, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж, тэгш боломж олгох, стандарт, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;
- Ажилтны ажил эрхэлсэн түүх, цалин, үр дүнгийн үнэлгээ, мэргэшил, сургалт, авсан болон хуримталсан амралт, чөлөөний тухай мэдээллийг хөтөлж, шинэчилж, тайлагнаж байх;
- Ажилд авах зарлал, шалгалтын зарлалыг гадагш илгээх;
- Ажилд орох болон тушаал дэвшихийг хүссэн өргөдөл, анкет зэргийг хүлээн авах, удирдлагад танилцуулах, ажлын ярилцлага зохион байгуулах, үр дүнг нь өргөдөл гаргагчдад мэдэгдэх;
- Ажлаас чөлөөлөгдсөн, ажилд шинээр орсон, түр хугацаагаар ажил гүйцэтгэх, албан тушаал орлон гүйцэтгэх ажилтны материалыг удирдлагад танилцуулах;
- Шинээр томилогдсон ажилтнуудын бүртгэл, мэдээллийг хөтөлж эхлэх, бүртгэл, мэдээллийн бүрэн эсэхийг шалгах;
- Байгууллагын ажил мэргэжлийн лавлах, ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ зэрэг баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэх;

- Ажлын нөхцөл, хангамжийн талаарх асуулт, лавлагааг хүлээн авч шийдвэрлүүлэх;
- Ажлын цаг ашиглалт, бүртгэлд хяналт тавьж, ажилтны чөлөө авсан, тасалсан цагуудад мониторинг хийж, удирлагад танилцуулах;
- Хүний нөөцийн талаар удирдлагыг мэдээллээр хангах, үйл ажиллагаатай холбогдох тайлан, бичиг баримтуудыг цуглуулж эмхэтгэх, тайлагнах, архивлан хадгалах.

1.2.3. Хөдөлмөрлөх орчны эрүүл ахуйн нөхцөл, зохион байгуулалт, ажлын дэглэм

- Ажлын байр нь хэвийн нөхцөлтэй, дулаан байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй байна.
- Ажлын байр нь эрүүл ахуйн болон хөдөлмөрийн аюулгүй байдлын зохих шаардлагыг хангасан байна.
- Хөдөлмөрийн хууль тогтоомж, байгууллагын болон нэгжийн дотоод журмыг мөрдөж ажиллана.

1.2.4. Ажлын байранд ашиглах багаж хэрэгсэл

Хүний нөөцийн бүртгэлийн программ, маягтууд баримт бүхий компьютер, хэвлэгч, баримтаа эмхэлж цэгцлэхэд шаардлагатай хэрэгсэл, ажлын стандарт бичгийн ширээ, сандал, баримт бичгийн шүүгээ зэрэг.

1.2.5. Мэдлэг

- Төсвийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн албаны тухай, Соёлын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Музейн тухай зэрэг бусад холбогдох хууль, тогтоомж;
- Монгол хэлний хэл зүн дүрмийн мэдлэг, найруулан бичих өндөр чадвар;
- Сүүлийн үеийн дэвшилтэт программ хангамж, техник технологи, мэдээллийн орчинд ажиллах;
- Бусад байгууллага, нийгмийн даатгал, халамж, аудитын газар тооцоо хийх, мэдээлэл боловсруулах чадвар.

1.2.6. Мэргэжлийн ур чадвар

Хүний нөөц, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн бизнесийн талаар мэргэшсэн, төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах.

1.2.7. Хандлага

- Ажил үүргээ гүйцэтгэх хүсэл тэмүүлэлтэй,
- Харилцааны өндөр соёлтой,
- Ёс зүйн дүрмийг баримталдаг байх,
- Бусадтай зөв боловсон харьцах,
- Хувийн зохион байгуулалт болон цагийн менежмент сайтай,
- Ой тогтоолт, анхаарал төвлөрөлт сайтай, хурц хараа, ажигч гярхай,
- Суралцах, мэргэжил дээшлүүлэх хүсэл сонирхолтой,
- Хамт олны дунд биеэ зөв авч явдаг байх,
- Бусдын шийдвэрийг хүндэтгэдэг,
- Бүтээлч сэтгэлгээтэй байх.


1.3. Хүлээх хариуцлага

| | |
|------------------------------|---|
| Хэний өмнө хариуцлага хүлээх | - Соёлын өвийн үндэсний төвийн захирал - Захиргаа, удирдлагын газрын дарга |
| Удирдан ажиллах ажилтан | |

I.4. Мэргэжил дээшлүүлэх болон ирээдүйд ахиж дэвших боломж

| Холбогдох албан тушаалтан | Хөгжих дэвших боломж | | | Тусгай тэмдэглэл |
|-----------------------------------|----------------------|------|-------|-------------------|
| | Бага | Дунд | Өндөр | |
| Мэргэжил дээшлүүлэх боломж | | | + | |
| Удирдах албан тушаал | | | + | |
| Гүйцэтгэх албан тушаал | | | | Тэмдэглэл байхгүй |
| Өөр төрлийн ажил гүйцэтгэх боломж | | | + | |

---o0o---



Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2023 оны 06 дугаар сарын 16-ны
өдрийн 4.47 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

I. ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗАР

Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

I.1. Ажлын байрны товч тодорхойлолт

Байгууллагын гадаад харилцааг бэхжүүлэн хөгжүүлэх, олон улсын ижил төрлийн байгууллагуудтай чанар үр дүнтэй, олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, Дэлхийн өвийн жагсаалтад бүртгэгдсэн Монголын соёлын өв болон уг жагсаалтад нэр дэвшүүлэх соёлын өвийн баримт бичигт холбогдох хүмүүст техник, арга зүйн дэмжлэг үзүүлэх, тайлан баримт бичгийг хүлээн авч нэгтгэх, орчуулах, илгээх, дэлхийн өвийн асуудлаар ЮНЕСКО-ийн холбогдох байгууллага болон гадаадын улс орнуудтай харилцах асуудлыг зохион байгуулан гүйцэтгэх.

| | |
|--|--|
| Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт (YAMAT-08) дахь мэргэжлийн индекс код | 2422-24 |
| Олон улсын ажил мэргэжлийн ангилал (ISCO-08) | 2422 |
| Боловсруулсан огноо | 2022 оны 5 дугаар сарын 25 |
| Баталсан байгууллага | Соёлын өвийн үндэсний төв |
| Хянан засварлах хугацаа | YAMAT эсвэл хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон |

I.2. Ажлын байрны тухай мэдээлэл

I.2.1. Ажил мэргэжлийн ерөнхий ба тусгай бэлтгэл

Гадаад харилцаа, гадаад хэлний орчуулагч, хууль, нийгэм, соёл, урлаг, хүмүүнлэгийн мэргэжлийн чиглэлээр магистр, түүнээс дээш зэрэгтэй.

I.2.2. Гүйцэтгэх үүрэг:

- Байгууллагын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудлыг төлөвлөх, зохицуулах;
- Гадаадын ижил төрлийн мэргэжлийн байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ хийх, санамж бичиг байгуулах ажлыг зохион байгуулах;
- Гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төслийг зохицуулах;
- Олон улсын гэрээ, конвенц, гадаад орны Засгийн газар, яам хоорондын салбарын гэрээ, хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулахад мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;
- Гадаад улсад мэргэжил дээшлүүлэх, шинээр эзэмшүүлэх, мэргэшүүлэх шаардлагатай мэргэжлийн чиглэлийг тодорхойлж, ажилтнуудыг гадаад сургалтад оролцуулах, хамруулах ажлыг зохион байгуулах;
- Ажилтан, албан хаагчид гадаадад хурал, семинар, сургалтад хамрагдсан талаар, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар бүртгэл, тайлан хөтлөх;

- Гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрт хамааралтай ажиллаж байгаа бусад чиглэлийн мэргэжилтнүүдийг мэдээллээр хангах;
- Байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлж болохуйц гадаадын тэргүүн туршлага, технологийн талаар санал санаачилгыг бүртгэх, сан үүсгэх, шаардлагатай тохиолдолд холбогдох албан тушаалтанд танилцуулах;
- Гадаадад халин гарсан Монголын соёлын өв дурсгалыг эрэн сурвалжлах, мэдээлэл цуглуулах, бүртгэх, мэдээллийн сан бүрдүүлэх ажилд дэмжлэг үзүүлж, холбогдох байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах;
- ЮНЕСКО-ийн Дэлхийн өвийн жагсаалтад бүртгэгдсэн Монголын соёлын өвийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, тайлан мэдээг хүлээн авч нэгтгэх, орчуулах, холбогдох байгууллагуудад хүргүүлэх ажлыг зохион байгуулах;
- Дэлхийн өвийн жагсаалтад нэр дэвшүүлэх соёлын өвийн баримт бичигт холбогдох хүмүүст техник, арга зүйн дэмжлэг үзүүлэх;
- Дэлхийн өвийн асуудлаар ЮНЕСКО-ийн холбогдох байгууллага, төвүүдтэй хамтран ажиллах, албан бичиг төлөвлөх, ирсэн захидал, баримт бичиг цэгцлэх, илгээх;
- Байгууллагын гадаад хамтын ажиллагааны холбогдолтой цаасан болон цахим албан хэрэг хөтлөлт баримт бичгийг эмхлэн цэгцлэх, архивын нэгж болгон ангилан төрөлжүүлж, данс бүртгэлд оруулах ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

1.2.3. Хөдөлмөрлөх орчны эрүүл ахуйн нөхцөл, зохион байгуулалт, ажлын дэглэм

- Ажлын байр нь хэвийн нөхцөлтэй, дулаан байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй байна.
- Ажлын байр нь эрүүл ахуйн болон хөдөлмөрийн аюулгүй байдлын зохих шаардлагыг хангасан байна.
- Хөдөлмөрийн хууль тогтоомж, байгууллагын болон нэгжийн дотоод журмыг мөрдөж ажиллана.

- Соёлын биет бус өвийг авран хамгаалах чиглэлээр төрийн байгууллага, аж ахуйн нэгж, хуулийн этгээд, иргэнтэй хамтран ажиллах;
- Соёлын биет бус өвд учирч байгаа эрсдэлийн хүчин зүйлсийг судлах, эрсдэлд дүн шинжилгээ, үнэлгээ хийж тодорхойлох;
- Соёлын биет бус өв, түүнийг авран хамгаалах чиглэлээр судалгаа, сурталчилгааны бүтээл бичих, хэвлэн нийтлүүлэх;
- Соёлын биет бус өвийг авран хамгаалах үйл ажиллагаатай холбоотой тоон дүн мэдээ гаргах, хөтлөх, нэгтгэх, бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх;

- Ажлын зайлшгүй шаардлагаар илүү цагаар ажиллах, нууц хадгалах, томилолтоор ажиллах.

VI.2.3. Хөдөлмөрлөх орчны эрүүл ахуйн нөхцөл, зохион байгуулалт, ажлын дэглэм

- Ажлын байр нь хэвийн нөхцөлтэй, дулаан байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй байна.
- Ажлын байр нь эрүүл ахуйн болон хөдөлмөрийн аюулгүй байдлын зохих шаардлагыг хангасан байна.
- Хөдөлмөрийн хууль тогтоомж, байгууллагын болон нэгжийн дотоод журмыг мөрдөж ажиллана.

VI.2.4. Ажлын байранд ашиглах багаж хэрэгсэл

Компьютер, хэвлэгч, ажлын стандарт бичгийн ширээ, сандал, бүртгэл, каталогийн шүүгээ, дүрс бичлэгийн камер, зургийн аппарат, ажлын хувцас, хэрэглэл зэрэг.

VI.2.5. Мэдлэг

- Соёлын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Хөдөлмөрийн хууль, Соёлын өвийн үндэсний төвийн дүрэм, байгууллагын дотоод журам;
- Соёлын өвийг бүртгэх, мэдээллийн сан бүрдүүлэх тухай холбогдох дүрэм, журам, ажлын байрны зохион байгуулалтын онцлог;
- Соёлын биет бус өвд учирч байгаа эрсдэлийн хүчин зүйлсийг тодорхойлох;
- Соёлын биет бус өвийн эрсдэлийн харилцааг зохицуулах;
- Тоон дүн мэдээ гаргах, хөтлөх, бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх;
- Арга зүйн заавар зөвлөмж өгөх, сургалт зохион байгуулах;
- Гэрэл зургийн аппарат, ердийн хэрэглээний дүрс бичлэгийн аппарат сайн эзэмшсэн байх.

VI.2.6. Мэргэжлийн ур чадвар

Соёлын биет бус өвийг таньж тогтоох, тодорхойлох, бүртгэх ажлыг гүйцэтгэх, зохион байгуулах, төлөвлөх, тайлагнах, илтгэх.

VI.2.7. Хандлага

- Ажил үүргээ гүйцэтгэх хүсэл тэмүүлэлтэй,
- Харилцааны өндөр соёлтой,
- Ёс зүйн дүрмийг баримталдаг байх,
- Бусадтай зөв боловсон харьцах,
- Хувийн зохион байгуулалт болон цагийн менежмент сайтай,
- Суралцах, мэргэжил дээшлүүлэх хүсэл сонирхолтой,
- Хамт олны дунд биеэ зөв авч явдаг байх,
- Бусдын шийдвэрийг хүндэтгэдэг,
- Бүтээлч сэтгэлгээтэй байх,
- Хөдөө орон нутагт удаан хугацаанд ажиллах ачаалал даах.

VI.3. Хүлээх хариуцлага

| | |
|------------------------------|--|
| Хэний өмнө хариуцлага хүлээх | - Соёлын үндэсний төвийн захирал - Авран хамгаалах, эрсдэлийн судалгааны газрын дарга |
| Удирдан ажиллах ажилтан | |

VI.4. Мэргэжил дээшлүүлэх болон ирээдүйд ахиж дэвших боломж

| Холбогдох албан тушаалтан | Хөгжих дэвших боломж | | | Тусгай тэмдэглэл |
|-----------------------------------|----------------------|------|-------|-------------------|
| | Бага | Дунд | Өндөр | |
| Мэргэжил дээшлүүлэх боломж | | | + | |
| Удирдах албан тушаал | | | + | |
| Гүйцэтгэх албан тушаал | | | | Тэмдэглэл байхгүй |
| Өөр төрлийн ажил гүйцэтгэх боломж | | | + | |

---oOo---

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2023 оны 06 дугаар сарын 16-ны
өдрийн 0187 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт



VII. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР

Мэдээллийн технологийн газрын дарга

VII.1. Ажлын байрны товч тодорхойлолт

Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн соёлын биет ба биет бус өвийн цахим бүртгэлийн программ хангамжийн ашиглалт, аюулгүй байдал, хадгалалт болон программ хангамжийн шинэчлэлт, хөгжүүлэлтийн хөгжлийг төлөвлөх, чиглүүлэх, зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, Үндэсний төвийн албан ажлын компьютерын болон харилцаа холбооны системийн засвар үйлчилгээ, ашиглалт, хөгжил төлөвлөлтийг удирдан зохион байгуулах.

| | |
|--|--|
| Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт (YAMAT-08) дахь мэргэжлийн индекс код | 1213-12 1330-13 |
| Олон улсын ажил мэргэжлийн ангилал (ISCO-08) | 1213 1330 |
| Боловсруулсан огноо | 2022 оны 5 дугаар сарын 25 |
| Баталсан байгууллага | Соёлын өвийн үндэсний төв |
| Хянан засварлах хугацаа | YAMAT эсвэл хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон |

VII.2. Ажлын байрны тухай мэдээлэл

VII.2.1. Ажил мэргэжлийн ерөнхий ба тусгай бэлтгэл

Мэдээллийн технологи, программ хангамж, түүх, соёлын мэргэжлийн чиглэлээр магистр, түүнээс дээш зэрэгтэй.

VII.2.2. Гүйцэтгэх үүрэг:

- Мэдээлэл технологийн газрын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, ажиллагааны явцад дүн шинжилгээ хийх, бодлого төлөвлөгөөг боловсруулах, чиглүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;
- Төрөөс хэрэгжүүлж буй “Цахим монгол” системд соёлын биет ба биет бусийн өвийн бүртгэлийн программ хангамжуудыг холбох, хөгжүүлэхэд хамтран оролцох, зохион байгуулах;
- Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн ERP нэгдсэн сүлжээг ашиглах, хөтлөх, зохион байгуулахад удирдлагаар хангах;
- Соёлын өвийн цахим бүртгэл, мэдээллийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх, удирдлага зохион байгуулалтаар хангах;
- Соёлын биет ба биет бус өвийн программ хангамжийн шинэчлэлт, хөгжүүлэлтийн хэтийн хөгжлийг төлөвлөх, боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих;
- Компьютерын хэрэглээний болон системийн шаардлагыг хангахуйц технологийг тодорхойлох үүднээс удирдлага, хэрэглэгчид, техникийн ажилтнуудтай зөвлөлдөх;

- Соёлын өвийн бүртгэлийн системийн аюулгүй байдлыг хангах, системийн задлан шинжээч, программ зохиогч, компьютерын чиглэлийн бусад ажилтанд ажил хуваарилах, хянах, байгууллагын технологийн хэрэглээ болон хэрэгцээнд үнэлгээ хийх;
- Техник хангамж болон программ хангамжийг ашиглах, шинэчлэх талаар зөвлөмж гаргах, сургалт зохион байгуулах;
- Соёлын өвийг хадгалж хамгаалах, мэдээллийн технологи аюулгүй байдлын чиглэлээр олон нийттэй холбоо харилцаа тогтоож, уулзалт, хурал зөвлөгөөн, хандивын үйл ажиллагаанд оролцох;
- Мэдээлэл технологитой холбоотой асуудлаар хурал, зөвлөгөөн, семинарт байгууллагыг төлөөлөн оролцох.

VII.2.3. Хөдөлмөрлөх орчны эрүүл ахуйн нөхцөл, зохион байгуулалт, ажлын дэглэм

- Ажлын байр нь хэвийн нөхцөлтэй, дулаан байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй байна.
- Ажлын байр нь эрүүл ахуйн болон хөдөлмөрийн аюулгүй байдлын зохих шаардлагыг хангасан байна.
- Хөдөлмөрийн хууль тогтоомж, байгууллагын болон нэгжийн дотоод журмыг мөрдөж ажиллана.

VII.2.4. Ажлын байранд ашиглах багаж хэрэгсэл

Мэдээллийн технологийн холбогдолтой баримт бичиг бүхий, өндөр хүчин чадалтай компьютер, мэргэжлийн болон хэрэглээний программ хангамж, хэвлэгч, ажлын стандарт бичгийн ширээ, сандал, бүртгэл, каталогийн шүүгээ зэрэг.

VII.2.5. Мэдлэг

- Хөдөлмөрийн тухай, Кибер аюулгүй байдлын тухай, Харилцаа холбооны тухай, Соёлын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Музейн тухай болон бусад холбогдох хууль, тогтоомж;
- Соёлын өвийг бүртгэх, мэдээллийн сан бүрдүүлэх тухай холбогдох дүрэм, журам, ажлын байрны зохион байгуулалтын онцлог;
- Хэрэглээний болон мэргэжлийн программ хангамжуудын мэдлэгтэй;
- Программчлалын хэлний мэдлэгтэй;
- Системийн тест хийх, системийн анализ хийх мэргэжлийн мэдлэгтэй;
- Oracle, MSSQL мэдээллийн баазуудын талаар ерөнхий мэдлэгтэй.

VII.2.6. Мэргэжлийн ур чадвар

- Мэдээллийн технологи сүлжээний талаар мэргэжлийн өндөр мэдлэг, туршлагатай;
- Асуудал шийдвэрлэх ур чадвартай;
- Дүн шинжилгээ хийх ур чадвартай;
- Өндөр ачаалалтай орчинд ул суурьтай шийдвэр гаргах чадвартай;
- Харилцааны болон хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлж харилцах өндөр чадвартай;
- Бие даан ажиллах арга барил, сахилга баттай;

VII.2.7. Хандлага

- Ажил үүргээ гүйцэтгэх хүсэл тэмүүлэлтэй,
- Харилцааны өндөр соёлтой,
- Багаар ажиллах чадвартай,
- Ёс зүйн дүрмийг баримталдаг байх,
- Бусадтай зөв боловсон харьцах,
- Хувийн зохион байгуулалт болон цагийн менежмент сайтай,

- Ой тогтоолт, логик сэтгэлгээтэй, анхаарал төвлөрөлт сайтай,
- Тогтвор суурьшилтай ажиллах хүсэлтэй,
- Суралцах, мэргэжил дээшлүүлэх хүсэл сонирхолтой,
- Хамт олны дунд биеэ зөв авч явдаг байх,
- Бусдын шийдвэрийг хүндэтгэдэг,
- Бүтээлч сэтгэлгээтэй байх,
- Хөдөө орон нутагт удаан хугацаанд ажиллах ачаалал даах.

VII.3. Хүлээх хариуцлага

| | |
|------------------------------|---|
| Хэний өмнө хариуцлага хүлээх | <ul style="list-style-type: none"> - Соёлын өвийн үндэсний төвийн захирал - Захиргаа, удирдлагын газрын дарга |
| Удирдан ажиллах ажилтан | <ul style="list-style-type: none"> - Программист - Компьютер графикч - Инженер (Газар зүйн мэдээллийн зайнаас тандан судлах (GIS)) - Оператор |

VII.4. Мэргэжил дээшлүүлэх болон ирээдүйд ахиж дэвших боломж

| Холбогдох албан тушаалтан | Хөгжих дэвших боломж | | | Тусгай тэмдэглэл |
|-----------------------------------|----------------------|------|-------|-------------------|
| | Бага | Дунд | Өндөр | |
| Мэргэжил дээшлүүлэх боломж | | | + | |
| Удирдах албан тушаал | | | + | |
| Гүйцэтгэх албан тушаал | | | | Тэмдэглэл байхгүй |
| Өөр төрлийн ажил гүйцэтгэх боломж | | | + | |

---oOo---

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2023 оны 06 дугаар сарын 26-ны
өдрийн 107 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт



VII. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР

Программист

VII.1. Ажлын байрны товч тодорхойлолт

Шат, шатны бүртгэл, мэдээллийн сангийн соёлын биет болон биет бус өвийн цахим бүртгэлийн программын найдвартай ажиллагаа болон мэдээллийн нэгдсэн цахим санг хариуцах, байгууллагын үйл ажиллагааны интернет сүлжээ, дохиолол хяналтыг сүлжээнд холбох, компьютер, программ хангамж, цахим сүлжээ, мэдээллийн нууцлал, түүний аюулгүй байдал, цахим сангийн техникийн хэвийн, аюулгүй ажиллагааг хангах, бүртгэл, мэдээллийн сангуудын дундын өгөгдлийн санг байгуулж, төрийн болон холбогдох бусад байгууллагыг нэгдсэн сүлжээнд хамруулах.

| | |
|--|--|
| Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт (YAMAT-08) дахь мэргэжлийн индекс код | 1330-13 |
| Олон улсын ажил мэргэжлийн ангилал (ISCO-08) | 1330 |
| Боловсруулсан огноо | 2022 оны 5 дугаар сарын 25 |
| Баталсан байгууллага | Соёлын өвийн үндэсний төв |
| Хянан засварлах хугацаа | YAMAT эсвэл хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон |

VII.2. Ажлын байрны тухай мэдээлэл

VII.2.1. Ажил мэргэжлийн ерөнхий ба тусгай бэлтгэл

Мэдээллийн технологи, программист, түүх, соёлын мэргэжлийн чиглэлээр бакалавр, түүнээс дээш зэрэгтэй.

VII.2.2. Гүйцэтгэх үүрэг:

- Соёлын өвийн цахим бүртгэл мэдээллийн систем, программ хангамж нэвтрүүлэхэд шийдлийг боловсруулах, нэмэлт өөрчлөлт хийх, хөгжүүлэх болон сонголт хийх, санал дүгнэлт гаргах, программ хангамжтай холбоотой төслүүдийг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;
- Төрөөс хэрэгжүүлж буй “Цахим монгол” системд соёлын биет ба биет бусийн өвийн бүртгэлийн программ хангамжуудыг холбох, хөгжүүлэхэд хамтран оролцох, зохион байгуулах;
- Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн ERP нэгдсэн сүлжээг ашиглах, хөтлөх, зохион байгуулахад бусад газар нэгжүүдтэй хамтрах;
- Соёлын өвийн цахим бүртгэл, мэдээллийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх;
- Соёлын биет ба биет бус өвийн программ хангамжийн шинэчлэлт, хөгжүүлэлтийн хэтийн хөгжлийг төлөвлөх, боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих;
- Программд туршилтын мэдээллүүдийг оруулан ажиллуулж, шаардлагатай тохиолдолд өөрчлөх ба программын ажиллагааны явцад гарч буй мэдээлэл, зааварчилгааг зөв эсэхийг хянах;

- Программ боловсруулах, кодолсон зааврыг тайлбарлах зэрэг программыг хэрэглэгчдэд шаардлагатай баримт бичгүүдийг бэлтгэх;
- Үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх, шинэ шаардлага нөхцөлд тохируулах, программын үйлдлийг өргөжүүлэх зорилгоор шинэчилж, засварлаж өргөжүүлэх ажлыг гардан гүйцэтгэх буюу удирдан хийлгэх;
- Байгууллагийн үйл ажиллагаанд мэдээллийн технологийг өргөн нэвтрүүлэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, технологийн шийдэл боловсруулах, нэвтрүүлэх, интернетийн холболт, хяналтын камер, дотуур утасны хуваарилалт, тэдгээрийн холболтыг хийж, сүлжээний аюулгүй байдал, хэвийн ажиллагааг хангах;
- Хэрэглэгчдэд зориулсан мэдээллийн систем, программыг хэрэглэх гарын авлага бэлтгэх.

VII.2.3. Хөдөлмөрлөх орчны эрүүл ахуйн нөхцөл, зохион байгуулалт, ажлын дэглэм

- Ажлын байр нь хэвийн нөхцөлтэй, дулаан байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй байна.
- Ажлын байр нь эрүүл ахуйн болон хөдөлмөрийн аюулгүй байдлын зохих шаардлагыг хангасан байна.
- Хөдөлмөрийн хууль тогтоомж, байгууллагын болон нэгжийн дотоод журмыг мөрдөж ажиллана.

VII.2.4. Ажлын байранд ашиглах багаж хэрэгсэл

Өндөр хүчин чадал бүхий суурин болон зөөврийн компьютер, дагалдах хэрэгсэл, хэвлэгч, олшруулагч, скайнер, программ хангамж, өндөр хурдны интернэт сүлжээ зэрэг.

VII.2.5. Мэдлэг

- Хөдөлмөрийн тухай, Кибер аюулгүй байдлын тухай, Харилцаа холбооны тухай, Соёлын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Музейн тухай болон бусад холбогдох хууль, тогтоомж.
- Хэрэглээний болон мэргэжлийн программ хангамжуудын мэдлэгтэй,
- Программчлалын хэлний мэдлэгтэй,
- Системийн тест хийх, системийн анализ хийх мэргэжлийн мэдлэгтэй,
- Oracle, MSSQL мэдээллийн баазуудын талаар ерөнхий мэдлэгтэй;

VII.2.6. Мэргэжлийн ур чадвар

- C++, JAVA зэрэг програмчлалын хэлүүдийг бүрэн эзэмшсэн,
- Комьпютерын техник хангамж болон физикийн үндсэн мэдлэгтэй,
- Бүх төрлийн үйлдлийн системийн ажиллах зарчим, хамгаалалтын программуудын мэдлэгтэй,
- Программын дизайн гаргах, хэрэглэгчдэд ойлгомжтой, хялбар интерфайс гаргадаг байх.

VII.2.7. Хандлага

- Ажил үүргээ гүйцэтгэх хүсэл тэмүүлэлтэй,
- Харилцааны өндөр соёлтой,
- Багаар ажиллах чадвартай,
- Ёс зүйн дүрмийг баримталдаг байх,
- Бусадтай зөв боловсон харьцах,
- Хувийн зохион байгуулалт болон цагийн менежмент сайтай,
- Ой тогтоолт, логик сэтгэлгээтэй, анхаарал төвлөрөлт сайтай,
- Тогтвор суурьшилтай ажиллах хүсэлтэй,
- Суралцах, мэргэжил дээшлүүлэх хүсэл сонирхолтой,
- Хамт олны дунд биеэ зөв авч явдаг байх,
- Бусдын шийдвэрийг хүндэтгэдэг,

- Бүтээлч сэтгэлгээтэй байх,
- Хөдөө орон нутагт удаан хугацаанд ажиллах ачаалал даах.

VII.3. Хүлээх хариуцлага


| | |
|------------------------------|---|
| Хэний өмнө хариуцлага хүлээх | - Соёлын өвийн үндэсний төвийн захирал - Мэдээллийн технологийн газрын дарга |
| Удирдан ажиллах ажилтан | |

VII.4. Мэргэжил дээшлүүлэх болон ирээдүйд ахиж дэвших боломж

| Холбогдох албан тушаалтан | Хөгжих дэвших боломж | | | Тусгай тэмдэглэл |
|-----------------------------------|----------------------|------|-------|------------------|
| | Бага | Дунд | Өндөр | |
| Мэргэжил дээшлүүлэх боломж | | | + | |
| Удирдах албан тушаал | | | + | |
| Гүйцэтгэх албан тушаал | | | + | |
| Өөр төрлийн ажил гүйцэтгэх боломж | | | + | |

---o0o---

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2023 оны 06 дугаар сарын 16-ны
өдрийн 027 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт



VII. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР

Компьютер графикч

VII.1. Ажлын байрны товч тодорхойлолт

Дуу, дүрс бичлэг, график, хөдөлгөөний дүрсийг ашиглан соёлын өвийг олон нийтэд сурталчлан таниулах цахим видео танилцуулга, баримтат нэвтрүүлэг, контентын график дизайныг хийх ба боловсруулах, компьютер график хийх, аудио, видео, дуу, дүрс бичлэг эвлүүлгийн төхөөрөмж дээр ажиллах зэрэг ажлыг хийж гүйцэтгэх.

| | |
|--|--|
| Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт (YAMAT-08) дахь мэргэжлийн индекс код | 1330-18 1330-19 1330-20 |
| Олон улсын ажил мэргэжлийн ангилал (ISCO-08) | 1330 |
| Боловсруулсан огноо | 2017 оны 12 дугаар сарын |
| Баталсан байгууллага | Соёлын өвийн үндэсний төв |
| Хянан засварлах хугацаа | YAMAT эсвэл хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон |

VII.2. Ажлын байрны тухай мэдээлэл

VII.2.1. Ажил мэргэжлийн ерөнхий ба тусгай бэлтгэл

Компьютер график, мэдээллийн технологи, түүх, соёл урлагийн мэргэжлийн чиглэлээр бакалавр, түүнээс дээш зэрэгтэй.

VII.2.2. Гүйцэтгэх үүрэг:

- Программ хангамж, программын хэл, үйлдлийн систем ашиглан урлаг, уран санаа хослуулсан интернэт хуудсуудыг үнэлэх, зохиох, бичих;
- Мультимедиа программ, арга хэрэгсэл, компьютер график, программын хэл зэргийг ашиглан соёлын өвийн мэдээлэл, сурталчилгааны дижитал хөдөлгөөнт дүрс, презентаци, аудио болон видео бичлэг зэргийн график дизайн зохиох, боловсруулах;
- Интернет, вэб хуудасны нууцлал, вэб сайтад тавих мэдээллийн багтаамж, хэрэглэгчийн хүртэц, мэдээлэл шинэчлэх, вэб сайт хувилан хадгалах, сэргээх төлөвлөгөөг хянах, хэрэгжүүлэх, үүний тулд байрлуулсан хаяг, нууцлал зэрэг вэб сайттай холбоотой асуудлаар сүлжээний мэргэжилтэнтэй зөвлөлдөх;
- Вэб хуудас хийх, байнга ажиллуулах, засварлах зорилгоор зураг, дуу, хэлний зэрэг тусгай файлуудыг компьютерын кодтой нийцүүлэх;
- Интернетийн стратеги, вэб хуудсанд суурилсан аргачлал, төлөвлөгөө боловсруулах, дүн шинжилгээ хийх зэрэгт туслалцаа үзүүлэх;
- Интернет онлайн хурал зөвлөгөөн, хэлэлцүүлэг зэргийн бичлэг хийх, монтажлах, дамжуулах үед хэрэглэгддэг электрон тоног төхөөрөмжид тохируулга хийж, ажиллуулах;

- Зохиомж, зохиолын санаа, зураг гэх мэт ажлын ерөнхий санааг ашиглан ажлын төлөвлөгөөг боловсруулах, аудио, видео хальс, холбогдох материалуудыг бүртгэх, аюулгүй орчинд хадгалах;
- Дуу бичигч, монтажлагч тоног төхөөрөмж ашиглан видео, баримтат нэвтрүүлэг, контент хийхэд хар дүрсийг монтажлах;
- Тухайн жилд хийгдсэн соёлын өвийн цахим сурталчилгааны файл, холбогдох материалыг архивын дүрэм, журмын дагуу товьёгжуулж, Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээлийн сан хариуцсан ажилтанд хүлээлгэн өгөх;

VII.2.3. Хөдөлмөрлөх орчны эрүүл ахуйн нөхцөл, зохион байгуулалт, ажлын дэглэм

- Ажлын байр нь хэвийн нөхцөлтэй, дулаан байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй байна.
- Ажлын байр нь эрүүл ахуйн болон хөдөлмөрийн аюулгүй байдлын зохих шаардлагыг хангасан байна.
- Хөдөлмөрийн хууль тогтоомж, байгууллагын болон нэгжийн дотоод журмыг мөрдөж ажиллана.

VII.2.4. Ажлын байранд ашиглах багаж хэрэгсэл

Мэргэжлийн компьютер, мэргэжлийн төрөл бүрийн зургийн, дизайны, эвлүүлгийн, эффектийн программууд, камер, зургийн аппарат, хэвлэх төхөөрөмжүүд, микрофон, чанга яригч, видео дэлгэц, прожектор, видео монитор, холбох утас кабель, дууны болон миксэнгийн удирдлага, самбар болон бусад электрон тоног төхөөрөмж, засварын болон ашиглалтын багаж, сэлбэг хэрэгсэл зэрэг.

VII.2.5. Мэдлэг

- Хэрэглээний болон мэргэжлийн программ хангамжуудын мэдлэгтэй,
- Интернет болон сүлжээний мэдлэгтэй,
- Техник хангамжийн талаар зохих хэмжээний мэдлэгтэй.

VII.2.6. Мэргэжлийн ур чадвар

- Комьпютер, холбогдох тоног төхөөрөмжийн техникийн болон программын жижиг гэмтлийг илрүүлэн засах чадвартай,
- Техникийн ба дизайны шийдэл гаргах зэрэг чадвартай,
- Багаар болон бие даан ажиллах чадвартай.

VII.2.7. Хандлага

- Ажил үүргээ гүйцэтгэх хүсэл тэмүүлэлтэй,
- Харилцааны өндөр соёлтой,
- Багаар ажиллах чадвартай,
- Ёс зүйн дүрмийг баримталдаг байх,
- Бусадтай зөв боловсон харьцах,
- Хувийн зохион байгуулалт болон цагийн менежмент сайтай,
- Ой тогтоолт, логик сэтгэлгээтэй, анхаарал төвлөрөлт сайтай,
- Тогтвор суурьшилтай ажиллах хүсэлтэй,
- Суралцах, мэргэжил дээшлүүлэх хүсэл сонирхолтой,
- Хамт олны дунд биеэ зөв авч явдаг байх,
- Бусдын шийдвэрийг хүндэтгэдэг,
- Бүтээлч сэтгэлгээтэй байх,
- Хөдөө орон нутагт удаан хугацаанд ажиллах ачаалал даах.

VII.3. Хүлээх хариуцлага


| | |
|------------------------------|---|
| Хэний өмнө хариуцлага хүлээх | - Соёлын өвийн үндэсний төвийн захирал - Мэдээллийн технологийн газрын дарга |
| Удирдан ажиллах ажилтан | |

VII.4. Мэргэжил дээшлүүлэх болон ирээдүйд ахиж дэвших боломж

| Холбогдох албан тушаалтан | Хөгжих дэвших боломж | | | Тусгай тэмдэглэл |
|-----------------------------------|----------------------|------|-------|------------------|
| | Бага | Дунд | Өндөр | |
| Мэргэжил дээшлүүлэх боломж | | | + | |
| Удирдах албан тушаал | | + | | |
| Гүйцэтгэх албан тушаал | | | + | |
| Өөр төрлийн ажил гүйцэтгэх боломж | | + | | |

---o0o---

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2023 оны 06 дугаар сарын 26-ны
өдрийн 477 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт



VII. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР

Инженер (Газар зүйн мэдээллийн зайнаас тандан судлах)

VII.1. Ажлын байрны товч тодорхойлолт

Газар зүйн мэдээллийн систем, зайнаас тандан судлалын арга аргачлал ашиглан соёлын өвийг бүртгэх, зураглах, мэдээлэл боловсруулах ажлыг гүйцэтгэх.

| | |
|--|--|
| Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт (YAMAT-08) дахь мэргэжлийн индекс код | 1330-16 1349-36 |
| Олон улсын ажил мэргэжлийн ангилал (ISCO-08) | 1330 1349 |
| Боловсруулсан огноо | 2022 оны 5 дугаар сарын 25 |
| Баталсан байгууллага | Соёлын өвийн үндэсний төв |
| Хянан засварлах хугацаа | YAMAT эсвэл хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон |

VII.2. Ажлын байрны тухай мэдээлэл

VII.2.1. Ажил мэргэжлийн ерөнхий ба тусгай бэлтгэл

Газар зүйн мэдээллийн систем, зайнаас тандан судлалын мэргэжлийн чиглэлээр бакалавр, түүнээс дээш зэрэгтэй.

VII.2.2. Гүйцэтгэх үүрэг:

- Газар зүйн мэдээллийн систем, зайнаас тандан судлалын арга аргачлал ашиглан түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрыг бүртгэх, зураглах, мэдээлэл боловсруулах;
- Орон зайн өгөгдлийн стандартад тулгуурлан соёлын өвийн өгөгдлийн сан үүсгэх;
- Газар зүйн мэдээллийн систем, зайнаас тандан судлалын чиглэлээр сэдэвчилсэн судалгаа хийх;
- Газар зүйн мэдээллийн систем, зайнаас тандан судлалын боловсруулалт ашиглан соёлын өвийн орон зайн дүн шинжилгээ хийх;
- Чиг үүрэгтэй холбоотой төсөл, хөтөлбөр боловсруулах, үйл ажиллагааны хөтөлбөр, арга хэмжээ төлөвлөх;

VII.2.3. Хөдөлмөрлөх орчны эрүүл ахуйн нөхцөл, зохион байгуулалт, ажлын дэглэм

- Ажлын байр нь хэвийн нөхцөлтэй, дулаан байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй байна.
- Ажлын байр нь эрүүл ахуйн болон хөдөлмөрийн аюулгүй байдлын зохих шаардлагыг хангасан байна.
- Хөдөлмөрийн хууль тогтоомж, байгууллагын болон нэгжийн дотоод журмыг мөрдөж ажиллана.

VII.2.4. Ажлын байранд ашиглах багаж хэрэгсэл

Компьютер, GIS-ын болон тандан судлалын программ, плотер, принтер, канон, төрөл бүрийн тоног төхөөрөмж, шугам, хэмжигч багажууд (auto level, hand level, rod гэх мэт) бичгийн цаас, GPS, луужин, дүрс бичлэгийн камер, зургийн аппарат, тодотгогч, ажлын хувцас, хэрэглэл зэрэг.

VII.2.5. Мэдлэг

- Хөдөлмөрийн тухай, Соёлын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Музейн тухай болон Газарын харилцаатай холбогдох бусад хууль, тогтоомж;
- Соёлын өвийг бүртгэх, мэдээллийн сан бүрдүүлэх тухай холбогдох дүрэм, журам, ажлын байрны зохион байгуулалтын онцлог;
- Соёл болон физик газар зүйн онцлогийг дүгнэн шинжих, газар зүйн мэдээллийн систем /GIS/ ашиглан мэдээлэл боловсруулж, дүн шинжилгээ хийх;
- GIS ашиглан боловсруулсан мэдээллээ улам сайжруулах, судалгааны үр дүнгийн тайлан бичиж танилцуулах;
- GIS болон газар зүйн мэдээлэл ашиглах талаар бусдад зөвлөгөө өгөх.

VII.2.6. Мэргэжлийн ур чадвар

- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг таньж тогтоох, тодорхойлох анхан шатны мэдлэгтэй, байршлын болон нийгэм, эдийн засгийн, газар зүйн салбар ухаануудын онол арга зүйд тулгуурлан соёлын өвийн талаар зохих түвшинд судалгаа, шинжилгээ явуулах чадвартай байх;
- Байр зүй, зураг зүйн уламжлалт арга технологийн зэрэгцээ агаар сансрын болон компьютерын зураглал, газар зүйн мэдээллийн систем, тандан судалгааны технологийг зохих түвшинд эзэмшсэн байх.

VII.2.7. Хандлага

- Ажил үүргээ гүйцэтгэх хүсэл тэмүүлэлтэй,
- Харилцааны өндөр соёлтой,
- Багаар ажиллах чадвартай,
- Ёс зүйн дүрмийг баримталдаг байх,
- Бусадтай зөв боловсон харьцах,
- Хувийн зохион байгуулалт болон цагийн менежмент сайтай,
- Ой тогтоолт, логик сэтгэлгээтэй, анхаарал төвлөрөлт сайтай,
- Тогтвор суурьшилтай ажиллах хүсэлтэй,
- Суралцах, мэргэжил дээшлүүлэх хүсэл сонирхолтой,
- Хамт олны дунд биеэ зөв авч явдаг байх,
- Бусдын шийдвэрийг хүндэтгэдэг,
- Бүтээлч сэтгэлгээтэй байх,
- Хөдөө орон нутагт удаан хугацаанд ажиллах ачаалал даах.

V.3. Хүлээх хариуцлага

| | |
|------------------------------|---|
| Хэний өмнө хариуцлага хүлээх | - Соёлын өвийн үндэсний төвийн захирал - Мэдээллийн технологийн газрын дарга |
| Удирдан ажиллах ажилтан | |


V.4. Мэргэжил дээшлүүлэх болон ирээдүйд ахиж дэвших боломж

| Холбогдох албан тушаалтан | Хөгжих дэвших боломж | | | Тусгай тэмдэглэл |
|----------------------------|----------------------|------|-------|------------------|
| | Бага | Дунд | Өндөр | |
| Мэргэжил дээшлүүлэх боломж | | | + | |

| | | | | |
|-----------------------------------|--|---|---|-------------------|
| Удирдах албан тушаал | | | + | |
| Гүйцэтгэх албан тушаал | | | | Тэмдэглэл байхгүй |
| Өөр төрлийн ажил гүйцэтгэх боломж | | + | | |

---o0o---

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2023 оны 06 дугаар сарын 16...-ны
өдрийн 1/27 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт



VII. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР

Оператор

VII.1. Ажлын байрны товч тодорхойлолт

Зориулалтын аудио, видео тоног төхөөрөмж дээр ажиллаж соёлын өвийн дуу, дүрс бичлэг хийх, гэрэл зураг авах, гэрэлтүүлэг, бусад эффекийн систем, тоног төхөөрөмж суурилуулах, ажиллуулах, бага зэргийн гэмтлийг засварлах, дуу, дүрс бичлэг эвлүүлгийн төхөөрөмж дээр ажиллах.

| | |
|--|--|
| Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт (YAMAT-08) дахь мэргэжлийн индекс код | 3521-35 3431-34 |
| Олон улсын ажил мэргэжлийн ангилал (ISCO-08) | 3521 3431 |
| Боловсруулсан огноо | 2022 оны 5 дугаар сарын 25 |
| Баталсан байгууллага | Соёлын өвийн үндэсний төв |
| Хянан засварлах хугацаа | YAMAT эсвэл хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон |

VII.2. Ажлын байрны тухай мэдээлэл

VII.2.1. Ажил мэргэжлийн ерөнхий ба тусгай бэлтгэл

Дуу, дүрс бичлэг, зураглаач, радио телевиз, түүх, соёл урлагийн мэргэжлийн чиглэлээр бакалавр, түүнээс дээш зэрэгтэй.

VII.2.2. Гүйцэтгэх үүрэг:

- Соёлын биет болон биет бус өвийн дуу, дүрс бичлэг хийх, гэрэл зураг авах;
- Дуу бичлэгийн тоног төхөөрөмжийн дуу, дүрсний гаралт, дуугаралтыг тохируулах, хянах, ажиллуулах, найруулах, засварлах;
- Томоохон арга хэмжээ, зураг авалт хийгдэх өрөөнд байрлал, хэмжилтийг хийх, эффекийг тогтоож бэхлэх;
- Радио, телевиз болон кабелийн хөтөлбөр, кино зурагт бичлэг хийх, монтажлах, дамжуулах үед хэрэглэгддэг электрон тоног төхөөрөмжид тохируулга хийж, ажиллуулах;
- Аудио болон видео тоног төхөөрөмжийн дизайн зургийг гаргах, шинэчлэх, урсгал засвар хийх;
- Тохиромжтой байрлалаар гэрэлтүүлгийн тоног төхөөрөмж болон бусад төхөөрөмжийг суурилуулж угсрах, аудио болон видео мэдээллийг нягтруулж дижитал болгож хадгалах;
- Зохиомж, зохиолын санаа, зураг гэх мэт ажлын ерөнхий санааг ашиглан ажлын төлөвлөгөөг боловсруулах, аудио, видео хальс, холбогдох материалуудыг бүртгэх, аюулгүй орчинд хадгалах;
- Байгууллагын албан ёсны цахим веб сайт, пэйж хуудас болон социал сувгуудад соёлын өвийг сурталчилсан контент, дүрс бичлэг байршуулах ажлыг зохион байгуулах;

- Дуу бичигч, монтажлагч тоног төхөөрөмж ашиглан киноны дуу бичиж, монтажлах.

VII.2.3. Хөдөлмөрлөх орчны эрүүл ахуйн нөхцөл, зохион байгуулалт, ажлын дэглэм

- Ажлын байр нь хэвийн нөхцөлтэй, дулаан байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй байна.
- Ажлын байр нь эрүүл ахуйн болон хөдөлмөрийн аюулгүй байдлын зохих шаардлагыг хангасан байна.
- Хөдөлмөрийн хууль тогтоомж, байгууллагын болон нэгжийн дотоод журмыг мөрдөж ажиллана.

VII.2.4. Ажлын байранд ашиглах багаж хэрэгсэл

Мэргэжлийн компьютер, төрөл бүрийн зургийн, дизайны, эвлүүлгийн, эффектийн програмууд, дүрс бичлэгийн камер, зургийн аппарат, хэвлэх төхөөрөмжүүд, микрофон, чанга яригч, видео дэлгэц, прожектор, видео монитор, холбох утас кабель, дууны болон миксэнгийн удирдлага, самбар болон бусад электрон тоног төхөөрөмж, засварын болон ашиглалтын багаж, сэлбэг хэрэгсэл зэрэг.

VII.2.5. Мэдлэг

- Хэрэглээний болон мэргэжлийн программ хангамжуудын мэдлэгтэй,
- Интернет болон сүлжээний мэдлэгтэй,
- Техник хангамжийн талаар зохих хэмжээний мэдлэгтэй.

VII.2.6. Мэргэжлийн ур чадвар

- Комьпютер, холбогдох тоног төхөөрөмжийн техникийн болон программын жижиг гэмтлийг илрүүлэн засах чадвартай,
- Техникийн ба дизайны шийдэл гаргах зэрэг чадвартай,
- Гэрэл зураг авах талаар мэргэшсэн байх.

VII.2.7. Хандлага

- Ажил үүргээ гүйцэтгэх хүсэл тэмүүлэлтэй,
- Харилцааны өндөр соёлтой,
- Багаар ажиллах чадвартай,
- Ёс зүйн дүрмийг баримталдаг байх,
- Бусадтай зөв боловсон харьцах,
- Хувийн зохион байгуулалт болон цагийн менежмент сайтай,
- Ой тогтоолт, логик сэтгэлгээтэй, анхаарал төвлөрөлт сайтай,
- Тогтвор суурьшилтай ажиллах хүсэлтэй,
- Суралцах, мэргэжил дээшлүүлэх хүсэл сонирхолтой,
- Хамт олны дунд биеэ зөв авч явдаг байх,
- Бусдын шийдвэрийг хүндэтгэдэг,
- Бүтээлч сэтгэлгээтэй байх,
- Хөдөө орон нутагт удаан хугацаанд ажиллах ачаалал даах.

VII.3. Хүлээх хариуцлага

| | |
|------------------------------|---|
| Хэний өмнө хариуцлага хүлээх | - Соёлын өвийн үндэсний төвийн захирал - Мэдээллийн технологийн газрын дарга |
| Удирдан ажиллах ажилтан | |

VII.4. Мэргэжил дээшлүүлэх болон ирээдүйд ахиж дэвших боломж

| Холбогдох албан тушаалтан | Хөгжих дэвших боломж | | | Тусгай тэмдэглэл |
|-----------------------------------|----------------------|------|-------|------------------|
| | Бага | Дунд | Өндөр | |
| Мэргэжил дээшлүүлэх боломж | | | + | |
| Удирдах албан тушаал | | + | | |
| Гүйцэтгэх албан тушаал | | | + | |
| Өөр төрлийн ажил гүйцэтгэх боломж | | + | | |

---oOo---

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2023 оны 06 дугаар сарын 16-ны
өдрийн 062 дугаар тушаалын
2 дугаар хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
 Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Соёлын өвийг хамгаалах тухай хууль,
2021.07.02
Соёлын сайдын 2022.04.28-ны өдрийн
А/116 дугаар тушаал

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Соёлын өвийн үндэсний төв

Нэгжийн нэр:

Захиргаа, удирдлагын газар

Албан тушаалын нэр:

Захиргаа, удирдлагын газрын дарга

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТҮ-11

Ажлын цаг:

08.30-17.30

Ажлын байрны албан ёсны байршил:

Хан-Уул дүүрэг, 21 дүгээр хороо, Буянт-Ухаа
2 хороолол

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Байгууллагын санхүү, захиргаа, хүний нөөц, бодлого, төлөвлөлт, судалгаа, олон нийтийн харилцаа, маркетинг болон нэгжийн ерөнхий үйл ажиллагааг төлөвлөх, бусад газар нэгжүүдийг удирдан чиглүүлэх, хянан зохицуулах.

Албан тушаалын зорилт:

- Захиргаа, менежментийн чиглэлээр газрын дарга нарт стратегийн төлөвлөлт, үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх, судалгаа, зөвлөгөөгөөр хангах;
- Байгууллагын үйл ажиллагааны тайлан, дүн мэдээг боловсруулах, судалгаанд суурилсан ирээдүйн хэтийн чиг төлөв байдлыг тодорхойлох, бүтцэд нэмэлт өөрчлөлт хийх, судалгаа гаргах;
- Байгууллагын материаллаг нөөцийг хөгжүүлэх, удирдах;
- Хөдөлмөрийн дотоод журам, байгууллагад мөрдөх дэг журам, зааврыг боловсруулж хэрэгжүүлэх;
- Ажилтны үйл ажиллагаагаа хэвийн явуулах болон үнэн бодитой, цаг үеийн мэдээллээр хангахад нь манлайлах, удирдах;
- Хэлэлцээр, хурал, цуглаан олон нийтийн арга хэмжээнд байгууллагаа төлөөлөх;
- Төсөв батлах, удирдах, хянах, нөөцийн үр ашигтай зарцуулалтыг хангах;
- Боловсон хүчний сонголт, гүйцэтгэлд хяналт тавих.

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр: Туслах -Т, Хариуцан гүйцэтгэх -Г Хянах -Х Шийдвэрлэх -Ш |
|---------------------------|--|--|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | <ol style="list-style-type: none"> Газрын дарга нарын ажлын төлөвлөлт, үйл ажиллагаагаа явуулахад нь холбогдох эрх зүйн хүрээнд зөвлөгөө өгөх; Хамтран дотоод үйл ажиллагааны журам боловсруулах; Байгууллагын стратеги төлөвлөлтийн дагуу тохирох менежментийг хэрэгжүүлэх талаар ажил зохиох; | Ажлын зохион байгуулалтыг сайжруулах | Г, Х, Ш |
| 2 дугаар зорилтын хүрээнд | <ol style="list-style-type: none"> Хууль журамд заасан хугацаанд дүн мэдээг боловсруулж, зохих газарт хүргүүлэх; Хэтийн чиг төлөвийн талаарх судалгаа хийх; Судалгааны үр дүнг хэрэгжүүлэх; | Байгууллагын төлөвлөлт, гүйцэтгэлийн чиглэлийн ажил сайжруулах | Х, Ш |
| 3 дугаар зорилтын хүрээнд | <ol style="list-style-type: none"> Хэрэгцээт тоног төхөөрөмжийн захиалгыг хянаж хэрэгцээт ажилтанд хуваарилуулах; Хэрэгцээт тоног төхөөрөмж, албан байрны нөхцөлийг судлан үзэж сайжруулах арга хэмжээг авах; | Үйл ажиллагааны тасралтгүй ажиллагааг хангах | Х, Ш |
| 4 дүгээр зорилтын хүрээнд | <ol style="list-style-type: none"> Байгууллагын хэмжээгээр мөрдөгдөж буй дүрэм, журмуудыг хянан үзэж цаг үеийн нөхцөл байдалтай тохируулж шинэчлэх; Батлагдаж хүчин төгөлдөр болсон журмуудын хэрэгжилтийг хангаж ажиллах; | Эрсдэлийг бууруулах, дэг журмыг сайжруулах | Г, Х, Ш |
| 5 дугаар зорилтын хүрээнд | <ol style="list-style-type: none"> Ажлын үнэлгээ, ажил мэргэжлийн ур чадварын мэдээллийг байнга шинээр бэлдэж танилцуулах, сургалт зохион байгуулах; Цаг үеийн мэдээллийг тухай бүр хүргэж ажиллах; | Ажилтнуудын үр бүтээлийг сайжруулах; | Х, Ш |
| 6 дугаар зорилтын хүрээнд | <ol style="list-style-type: none"> Байгууллагын ажлыг сурталчлах, төв болон дээд төрийн захиргааны байгууллагаас зохион байгуулж буй үйл ажиллагаа, байгууллагыг олон нийтэд сурталчлах ажлын төлөвлөлтийг хийж зохион байгуулах; Байгууллагын албан ёсны www.ncch.gov.mn сайтад оруулах газар нэгжийнхээ үйл ажиллагааны нээлттэй мэдээллийг бэлтгэх ажлыг удирдан зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих; | Байгууллагын нэр хүндийг өсгөх | Х, Ш |
| 7 дугаар зорилтын хүрээнд | <ol style="list-style-type: none"> Байгууллагын жил бүрийн төслийн хэрэгжилт, зарцуулалтыг хянаж дүгнэлт хийх, ирэх жилийн төлөвлөлт болон явж буй үйл ажиллагаанд дүгнэлт хийн санал боловсруулж, захиргааны зөвлөлд танилцуулах; Төсвийн зарцуулалт, нөөц үр ашгийг сайжруулах арга хэмжээг зохион байгуулах; | Эрсдэлийг бууруулах, санхүүгийн сахилгыг сайжруулах | Х, Ш |

| | | | |
|---------------------------|---|-----------------------------|---------|
| 8 дугаар зорилтын хүрээнд | 1. Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, түүнтэй холбоотой журам, холбогдох нэмэлт өөрчлөлтийг боловсруулж ажиллах; 2. Ажлын байранд сонгон шалгаруулалт хийх, ажлын байрны дүгнэлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, ур чадвартай, мэргэшсэн мэргэжлийн ажилтнуудыг сул орон тоо дээр нөхөх; | Ажилтны чадавхыг сайжруулах | Г, Х, Ш |
|---------------------------|---|-----------------------------|---------|

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

| | | |
|-----------|---|---|
| Боловсрол | Магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх | |
| Мэргэжил | Удирдахуйн ухаан, хууль эрх зүй, менежмент, түүх, соёл, соёлын өвийн чиглэлийн мэргэжилтэй байх | |
| Мэргэшил | Салбарын бодлогын хэрэгжилт, соёл, соёлын өвийн талаарх мэдлэг ойлголт өндөр, мэргэшсэн байх | |
| Туршлага | Төрийн албанд 5-аас доошгүй жил ажилласан байх | |
| Ур чадвар | Дүн шинжилгээ хийх | <ul style="list-style-type: none"> - Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах, илтгэх ур чадвартай байх; - Судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; |
| | Асуудал шийдвэрлэх | <ul style="list-style-type: none"> - Судалгаа хийх, үр дүнг байгууллагын үйл ажиллагаанд ашиглах; - Асуудал шийдвэрлэх, өөрийн ажлын чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулах; |
| | Багаар ажиллах | <ul style="list-style-type: none"> - Мэдлэг, туршлага, ур чадвараа бусадтай хуваалцах; - Хамт олны эерэг, нээлттэй уур амьсгалыг бүрдүүлэх; - Ажлын чиг үүргийн хүрээнд хамтарч ажиллах; |
| | Бусад | <ul style="list-style-type: none"> - Компьютерын хэрэглээний программ болон мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийг ашиглах чадвартай байх; - Монгол хэлний найруулга зүй, хэл зүйн дүрмийн өндөр мэдлэгтэй байх; - Монгол бичгээр унших, хэрэглээний программд бичих мэдлэг, чадвартай байх, - Гадаад хэлний мэдлэгтэй байх. |

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

- Соёлын өвийн үндэсний төвийн захирал


| | |
|---|--|
| <p><u>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u></p> <ul style="list-style-type: none"> - Бүртгэл, мэдээллийн газрын дарга - 1, - Хадгалалт хамгаалалт, технологи судалгааны газрын дарга - 1, - Сэргээн засварлах газрын дарга - 1, - Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг хамгаалах газрын дарга - 1, - Авран хамгаалах, эрсдэлийн судалгааны газрын дарга - 1, - Мэдээллийн технологийн газрын дарга - 1, - Үйлчилгээ, аюулгүй байдлын албаны дарга - 1 - Ерөнхий нягтлан бодогч - 1 - Тооцооны нягтлан бодогч - 1 - Захиргааны мэргэжилтэн - 1 | <p><u>Бусад харилцах субъект:</u></p> <ul style="list-style-type: none"> - Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, - Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, - Аймаг, нийслэлийн Соёл, урлагийн газар, - Төрийн болон 21 аймаг, нийслэл, орон нутгийн музей, - Соёлын өвийг өмчлөгч, эзэмшигч төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэд. |
|---|--|

| | |
|---|--|
| <ul style="list-style-type: none"> - Дотоод хяналт, шалгалтын ажилтан - 1 - Хүний нөөцийн ажилтан - 1 - Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн - 1 - Олон нийттэй харилцах ажилтан - 1 - Архив, бичиг хэргийн эрхлэгч - 1 - Нярав - 1 - Цахилгаанчин - 1 - Слесарь - 2 - Жолооч - 1 - Үйлчлэгч - 2 | |
|---|--|

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

| Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан: | Албан тушаалын тодорхойлолтыг баталсан: |
|---|--|
| <p>Албан тушаал: ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА</p> <p><i>Д. Нарантуяа</i> Д.НАРАНТУЯА (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)</p> <p>2023 оны 6 дугаар сарын 12-ны өдөр</p> | <p>Байгууллагын нэр: СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ</p> <p>Шийдвэрийн огноо: 2023.06.16</p> <p>Дугаар: <i>М27</i></p> <p>(тамга/тэмдэг)</p> <p>ЗАХИРАЛ <i>Г. Энхбат</i> Г.ЭНХБАТ (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)</p> <p>2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр</p> |

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2023 оны 2 дугаар сарын 16-ны
өдрийн 2 дугаар тушаалын
2 дугаар хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
 Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: Соёлын өвийг хамгаалах тухай хууль,
2021.07.02
Соёлын сайдын 2022.04.28-ны өдрийн
А/116 дугаар тушаал

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Соёлын өвийн үндэсний төв

Нэгжийн нэр:

Захиргаа, удирдлагын газар

Албан тушаалын нэр:

Үйлчилгээ, аюулгүй байдлын албаны дарга

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТҮ-11

Ажлын цаг:

08.30-17.30

Ажлын байрны албан ёсны байршил:

Хан-Уул дүүрэг, 21 дүгээр хороо, Буянт-Ухаа
2 хороолол

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Байгууллагын аюулгүй байдлыг хангах, үйлчилгээний үйл ажиллагааг төлөвлөх, зохицуулах, зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих зэрэг удирдах үйл ажиллагааг гүйцэтгэх.

Албан тушаалын зорилт:

- Байгууллага хэвийн үйл ажиллагааг хангах хүрээнд байрны үйлчилгээ, аюулгүй байдлыг хангах ажлыг удирдан зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах;
- Байгууллагын цэвэрлэгээ үйлчилгээ, гадна болон дотоод тохижилт, урсгал засвар, өвлийн бэлтгэл, бохир дулаан хангамж, тог цахилгаан болон дохиолол хяналтын системийн хэвийн үйл ажиллагааг хариуцах, хяналт тавих, мэдээлэх.

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр: Туслах -Т, Хариуцан гүйцэтгэх -Г Хянах -Х Шийдвэрлэх -Ш |
|--|---|--|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | <ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын үйлчилгээний чанар, хэмжээ, өртөг зардал, цаг хугацаа, ажиллах хүчин зэргийг нарийвчлан төлөвлөх, хариуцлагыг тодорхойлох; 2. Захиргаа, үйлчилгээний менежментийн асуудлаар бусад газар нэгжийн дарга нарыг зөвлөгөө, мэдээллээр хангах; 3. Үндэсний төвийн барилгын тог цахилгаан, дулаан хангамж, цэвэр, бохир, цэвэр усны хэрэглээ, ашиглалтыг хариуцан зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих, холбогдох байгууллага, ажилтнуудтай хамтран ажиллах; 4. Байгууллагын өрөө тасалгаа, заал танхимын хэвийн үйл ажиллагааг хангах, зохион байгуулах; 5. Байгууллага дээр зохион байгуулагдаж буй аливаа сургалт, хурал, зөвлөгөөн цуглаан зэрэг арга хэмжээний цэвэрлэгээ, үйлчилгээг хариуцах, зохион байгуулах; 6. Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, машин техникийн ашиглалт, хэрэглээнд хяналт тавих, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал, стандарт, шаардлагын хэрэгжилтийг хангуулах; 7. Байгууллагын дохиолол хамгааллын системийг шинэчлэх, байршуулах ажлыг зохион байгуулах, дохиолол хамгааллын системийн хэвийн үйл ажиллагаанд хяналт тавих, хэвийн ажиллагааны талаар шаардлагатай тохиолдолд Мэдээллийн технологийн газрын хариуцсан ажилтанд мэдэгдэх, засуулах зэрэг ажлыг зохион байгуулан ажиллах; 8. Үйлчилгээ, аюулгүй байдлын талаар удирдлагыг мэдээллээр хангах, үйл ажиллагаатай холбогдох тайлан, бичиг баримтуудыг цуглуулж эмхэтгэх, тайлагнах, архивлан хадгалах; | Байгууллагын үйлчилгээ, аж ахуйн ажлыг сайжруулах | Г, Х, Ш |
| 2 дугаар зорилтын хүрээнд | <ol style="list-style-type: none"> 1. Байрны урсгал засвар, өвлийн бэлтгэл, тог цахилгаан, бохир, дулаан хангамжийн асуудлаар гэрээ байгуулах, төсвийг төлөвлөх; 2. Байгууллагын автомашины хувийн хэрэг, автомашины болон жолоочийн тодорхойлолт, шилжүүлэн эзэмшүүлсэн бүртгэл, автомашины түлхүүр, багаж хэрэгслийг зохих журмын дагуу тогтмол бүртгэж, дугуй номероор нь тулгалт хийх байх; | Чиг үүргийн гүйцэтгэлийг чанар, мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэх | Г, Х, Ш |
| III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА | | | |
| Боловсрол | Диплом, бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх | | |

| | | |
|-----------|---|---|
| Мэргэжил | Менежер, нягтлан бодогч, эдийн засгийн болон нийгэм соёл, хүмүүнлэгийн чиглэлийн мэргэжилтэй байх | |
| Мэргэшил | | |
| Туршлага | Төрийн албанд 2-аас доошгүй жил ажилласан байх; | |
| Ур чадвар | Дүн шинжилгээ хийх | - Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах, илтгэх ур чадвартай байх; |
| | Асуудал шийдвэрлэх | - Судалгаа хийх, үр дүнг байгууллагын үйлчилгээ, аж ахуйн үйл ажиллагаанд төлөвлөх, ашиглах; - Асуудал шийдвэрлэх, өөрийн ажлын чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулах; |
| | Багаар ажиллах | - Мэдлэг, туршлага, ур чадвараа бусадтай хуваалцах; - Хамт олны эерэг, нээлттэй уур амьсгалыг бүрдүүлэх; - Ажлын чиг үүргийн хүрээнд хамтарч ажиллах; |
| | Бусад | - Компьютерын хэрэглээний программ болон мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийг ашиглах чадвартай байх; - Монгол хэлний найруулга зүй, хэл зүйн дүрмийн өндөр мэдлэгтэй байх; - Монгол бичгээр унших, хэрэглээний программд бичих мэдлэг, чадвартай байх; - Гадаад хэлний мэдлэгтэй байх; |

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

- Соёлын өвийн үндэсний төвийн захирал
- Захиргаа, удирдлагын газрын дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

- Цахилгаанчин-1
- Слесарь-2
- Жолооч-1
- Үйлчлэгч-2

Бусад харилцах субъект:

- Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага,
- Харьяалах дүүргийн цахилгаан, дулаан, ус, бохир болон хог ачилт зэрэг аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх холбогдох байгууллага

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаал: ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА

..... Д.НАРАНТУЯА

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2023 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Шийдвэрийн огноо: 2023.06.16

Дугаар: А/27 (тамга/тэмдэг)

ЗАХИРАЛ Г.ЭНХБАТ

(Гарын үсэг), (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2023 оны 06 дугаар сарын 16 ны өдөр

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2023 оны 06 дугаар сарын 16-ны
өдрийн 07/22 дугаар тушаалын
2 дугаар хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: Соёлын өвийг хамгаалах тухай хууль, 2021.07.02
Соёлын сайдын 2022.04.28-ны өдрийн А/116 дугаар тушаал

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

| | |
|---|---|
| Байгууллагын нэр: Соёлын өвийн үндэсний төв | Нэгжийн нэр: Захиргаа, удирдлагын газар |
| Албан тушаалын нэр: Ерөнхий нягтлан бодогч | Албан тушаалын ангилал, зэрэглэл: ТУ-8 |
| Ажлын цаг: 08.30-17.30 | Ажлын байрны албан ёсны байршил: Хан-Уул дүүрэг, 21 дүгээр хороо, Буянт-Ухаа 2 хороолол |
| Хөдөлмөрийн нөхцөл: Хэвийн | Онцгой нөхцөл: <input type="text"/> |

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:
Байгууллагын үйл ажиллагааны төсвийн бүрдүүлэлт, зарцуулалт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах, хөтлөх, мэдээллийн бүрдүүлэлтийг хянах, байгууллагын жилийн төсвийн төсөөлөл болон төсөвтэй холбоотой төлөвлөгөөг боловсруулж батлуулах, сар, улирал, жилийн тайлан болон нийгмийн даатгал, татвар, шилэн дансны мэдээ гаргах, байгууллагын удирдлагыг санхүүгийн шийдвэр гаргахад үнэн зөв мэдээллээр хангах.

- Албан тушаалын зорилт:**
- Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, санхүүгийн холбогдолтой бүртгэл хөтлөлтийг хянах, шалгах;
 - Байгууллагын санхүүгийн холбогдолтой тооллого, тооцоог хийж хянах, зохих бүртгэл хийх;
 - Байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааны тайлан хийх;
 - Байгууллагын аж ахуйн ажиллагаатай холбогдол бүхий төсөв хийх, гэрээ байгуулах, ажилтнуудын цалинг зохих журмын дагуу бодож олгох, хөрөнгийн зарцуулалт хийх, байгууллагуудтай тогтмол болон хувьсах зардлын тооцоо хийх, материаллаг нөөцийг хөгжүүлэх, зохицуулах, ашиглалтад хяналт тавих.

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр: Туслах -Т, Хариуцан гүйцэтгэх -Г Хянах -Х Шийдвэрлэх -Ш |
|---------------------------|---|--|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | <ol style="list-style-type: none"> Санхүүгийн бүх төрлийн анхан шатны бүртгэл хөтлөх, байгууллагуудтай байгуулсан гэрээнд хяналт тавьж, инкассын баримтуудыг шалгах; Автомашин бүрд хийсэн урсгал болон их засвар, запас сэлбэг хаанаас хэрхэн сольсон засварласан тухай тусгай бүртгэлд хяналт тавих; | Байгууллагын санхүүгийн данс, бүртгэл хөтлөлтийг төгөлдөржүүлэх | Г |
| 2 дугаар зорилтын хүрээнд | <ol style="list-style-type: none"> Тооцооны нягтлан бодогч болон няравын ажлын чиг үүрэгт хяналт тавих; Хагас, бүтэн жилийн үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг зохион байгуулах, хянах; Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 13,14,17,40-р зүйлд заасны дагуу ажиллах; Санхүү, аж ахуйн холбогдолтой баримт бичгийг бүрдүүлж зохих журмын дагуу цэгцлэх, үдэх, хадгалах, архивт шилжүүлэх; Ажилтнуудын сар бүрийн цалин, тэтгэвэр тэтгэмж амралт, илүү цагийн мөнгийг цаг тухайд нь тооцоолж олгох; Байгууллагын албан ёсны www.ncsch.gov.mn сайтад оруулах газар нэгжийнхээ үйл ажиллагааны нээлттэй мэдээллийг бэлтгэж өгөх; | Чиг үүргийн гүйцэтгэлийг чанар, мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэх, санхүүгийн сахилга баттай байх | Г, Х, Ш |
| 3 дугаар зорилтын хүрээнд | <ol style="list-style-type: none"> Санхүүгийн тооцоолох цахим программыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэглэж жил, улирал, сар бүрийн татварын тайлан баланс, нийгмийн даатгалын тайлан, төсвийн тайлан, мэдээ, санхүүгийн болон хөрөнгийн тайлан, хуульд заасан хугацаанд гаргах; Жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор дараа оны төсвийн төслийг үндэслэлтэй боловсруулж Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэх; Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн төсөл, төсвийн зарлага санхүүжилтийн гүйцэтгэлийн болон бүтээгдэхүүний тайланг тогтоосон хугацаанд холбогдох байгууллагад тайлагнах; Байгууллагын дулааны болон эрчим хүчний төлбөр, нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгал, татвар зэрэг бусад төлбөрийг цаг тухайд нь шилжүүлж холбогдох баримт материалыг бүрдүүлэх; Шилэн дансны цахим хуудсанд оруулсан мэдээллийг хянах, баталгаажуулах; Жилийн эцсийн тайлан баланст дүн шинжилгээ хийх; | Хуульд заасан чиг үүргийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах | Г, Х, Ш |
| 4 дүгээр зорилтын хүрээнд | 1. Байгууллагын эд аж ахуй, аж ахуйн материалаар тасралтгүй хангах ажлыг зохион байгуулах; | Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, | Г, Х, Ш |

| | | | |
|--|---|---|--|
